



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/147

Улаанбаатар хот

Шуурхай ажиллагааг зохион байгуулах журмыг шинэчлэн батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.19, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Шуурхай ажиллагааг зохион байгуулах журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, харьяа салбар, нэгжийн дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (бригадын генерал Ж.Чүлтэмсүрэн)-д даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2008 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн А/286, 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/149, 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/68, 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/126, 2022 оны 04 дүгээр сарын 11-ний А/94 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

142411153

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн
А/147 дугаар тушаалын хавсралт



ШУУРХАЙ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

1.1. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангах, мэдээ, мэдээлэл солилцох, шуурхай ажиллагааг зохион байгуулах арга хэмжээг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмыг Онцгой байдлын ерөнхий газар, дэргэдэх салбар, нэгж дагаж мөрдөнө.

1.3. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно:

1.3.1. "албаны өндөржүүлсэн бэлэн байдал" гэж гамшгийн нөхцөл байдал үүссэн болон үүсэж болзошгүй нөхцөлд онцгой байдлын байгууллагын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэхийг;

1.3.2. "шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч" гэж гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээ, мэдээллийг хүлээн авч дүн шинжилгээ хийж, шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах, харилцан ажиллагааг зохицуулах, холбогдох байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах чиг үүрэг бүхий алба хаагчийг;

1.3.3. "мэдээлэл хүлээн авах" гэж гамшиг, аюулт үзэгдэл, ослын тухай мэдээ, мэдээллийг хүлээн авах, цахим системд бүртгэх үйл ажиллагааг;

1.3.4. "мэдээлэл дамжуулах" гэж гамшиг, аюулт үзэгдэл, ослын тухай мэдээ, мэдээлэлд боловсруулалт хийж, холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэхийг;

1.3.5. "гамшгийн нөхцөл байдлын хоногийн мэдээ" гэж 24 цагийн хугацаанд тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, осол, хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний талаарх цахим болон цаасан мэдээллийг;

1.3.6. "ажиллагааны удирдагч" гэж үүссэн гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод салаа, бүлэг, тасгийг удирдаж байгаа албан тушаалтныг;

Хоёрдугаар бүлэг. Шуурхай удирдлага, зохион байгуулалт

2.1. Шуурхай ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

2.1.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын шуурхай удирдлага, зохицуулалтыг дараах түвшинд хэрэгжүүлнэ.

-улсын түвшинд: Онцгой байдлын ерөнхий газар,

-бүсийн түвшинд: Бүсийн төв-Онцгой байдлын газар;

-орон нутгийн түвшинд: Онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбар;

2.1.2. Энэхүү журмын 2.1-д заасан түвшинд шуурхай штаб, шуурхай ажлын хэсэг (цаашид "шуурхай бүлэг" гэх), ерөнхий эргүүл, хариуцлагатай жижүүрийг томилж ажиллуулна.

2.1.3. Гамшиг, аюул, ослын нөхцөл байдал, төрөл, цар хүрээг харгалзан 2-оос дээш гал унтраах, эрэн хайх аврах анги, салбар гал түймэр, гамшиг, ослын хариу арга хэмжээг зохион байгуулах тохиолдолд шуурхай штабыг байгуулж удирдлага, зохицуулалтаар хангана.

2.1.4. Шуурхай штабыг улсын хэмжээнд Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд болон дэд дарга, шуурхай бүлгийг зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, хэлтсийн дарга ахална.

2.1.5. Бүс, орон нутгийн түвшинд шуурхай штабыг бүсийн төвийн захирагч, болон онцгой байдлын газрын дарга, шуурхай бүлгийг онцгой байдлын газрын

орлогч, хэлтсийн дарга ахална.

2.1.6. Шуурхай штаб, шуурхай бүлэгт шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагыг татан оролцуулна.

2.1.7. Ерөнхий эргүүлээр Онцгой байдлын ерөнхий газарт зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, орон нутагт харьяа салбар нэгжийн дарга, захирагчийн тушаалаар томилогдсон алба хаагчийг ажиллуулна.

2.1.8. Гамшгийн үеийн шуурхай удирдлагыг суурин (байнгын) болон хөдөлгөөнт удирдлагын автомашинаас зохион байгуулна.

2.1.9. Шуурхай удирдлагын суурин байрлал ашиглах боломжгүй болсон нөхцөлд тусгайлан тоногдсон хөдөлгөөнт удирдлагын автомашин, зарлан мэдээллийн хөдөлгөөнт удирдлагын төв (автомашин) болон хөдөлгөөнт холбооны зангилааг (автомашин) ашиглана. Хөдөлгөөнт удирдлагын автомашин болон хөдөлгөөнт холбооны зангилаа, зарлан мэдээллийн хөдөлгөөнт удирдлагын төвийг энэхүү журмын 5, 6, 7 дугаар хавсралтын дагуу тоноглож байнгын бэлэн байдалд байлгана.

2.1.10. Шуурхай штаб болон шуурхай бүлэгт шаардлагатай автомашиныг Онцгой байдлын ерөнхий газар, нийслэл, төв, орон нутгийн онцгой байдлын газарт байнгын бэлэн байдалд байрлуулж, шуурхай албаны автомашины жолоочийг 24 цагаар томилж ажиллуулна.

2.2. Шуурхай штабын үйл ажиллагаа

2.2.1. Шуурхай штабын бүрэлдэхүүн нь штабын даргын удирдлагад ажлын тусгай горимоор үүрэг гүйцэтгэнэ.

2.2.2. Шуурхай штаб нь гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах арга хэмжээг төлөвлөн, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, биелэлтэд хяналт тавина.

2.2.3. Гамшгийн голомтод аврах, эрэн хайх, хор уршгийг арилгах томилгоот бүрэлдэхүүн, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, харьяа салбар нэгжтэй үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.

2.2.4. Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, нэрвэгдэгсдэд шуурхай тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд шаардагдах хүн хүч, техник хэрэгслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу дайчлах шийдвэр гаргана.

2.2.5. Гамшгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулан, боловсруулалт, дүн шинжилгээ хийж удирдлагыг мэдээллээр хангана.

2.2.6. Гамшгийн голомтод ажиллаж байгаа алба хаагчдын хоол хүнс, хувцас, шатахууны болон бусад хангалтыг зохион байгуулж хяналт тавина.

2.2.7. Гамшгийн үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгахад шаардлагатай материал техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нөөц, хэрэгцээ шаардлагыг тодорхойлно.

2.2.8. Гамшгийн голомтод үүссэн нөхцөл байдал авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, гарсан өөрчлөлтийг ажлын болон шийдвэрийн зурагт оруулна.

2.2.9. Гамшгийн нөхцөл байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар иргэд олон нийтэд мэдээлнэ.

2.2.10. Шуурхай штабын үндсэн болон нөөц бүрэлдэхүүнийг энэхүү журмын "Хүснэгт 2, Хүснэгт 3"-т заасны дагуу, шуурхай штабын байрны иж бүрдлийг "Хүснэгт 6"-д заасны дагуу бүрдүүлж ажиллуулна.

2.3. Шуурхай бүлгийн үйл ажиллагаа

2.3.1. Гамшгийн аюул үүссэн буюу үүсэж болзошгүй нөхцөл байдлын үед Шуурхай бүлгийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, харьяа салбар нэгжийн даргын шийдвэрээр ажиллуулна.

2.3.2. Шуурхай бүлэг нь гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагааг шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах,

гамшгаас хамгаалах улсын алба, байгууллага, хуулийн этгээдийн харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг үүрэгтэй ажиллана.

2.3.3. Шуурхай бүлгийг ажиллах нөхцөл, шаардлагатай техник, хэрэгслээр хангана.

2.3.4. Шуурхай бүлгийн ахлагчийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, дэд дарга, орон нутагт бүсийн төв, аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Онцгой байдлын газар, хэлтэс, дэргэдэх анги, байгууллагын дарга, захирагч нар шууд удирдлагаар хангаж ажиллана.

2.3.5. Шуурхай бүлгийн үндсэн болон нөөц бүрэлдэхүүнийг энэхүү журмын "Хүснэгт 3"-т заасны дагуу, техник хэрэгслийг Хүснэгт 7"-д заасны дагуу бүрдүүлнэ.

2.4. Гамшиг ослын дуудлагад ажиллах салаа, бүлгийн үйл ажиллагаа

2.4.1. Гамшиг осол, аюулт үзэгдлийн анхны дуудлагаар түрүүлж очсон салаа, бүлэг, тасгийн дарга голомтын бүсэд ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлнэ.

2.4.2. Ажиллагааны удирдагч нь үүссэн нөхцөл байдлыг үнэлэн хэрэгжүүлэх арга хэмжээний дарааллыг тогтоон байгаа хүч хэрэгсэлдээ тулгуурлан хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.4.3. Нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээллийг анги байгууллага, удирдлагад мэдэгдэж, шаардлагатай нэмэлт хүч хэрэгслийн захиалга өгч, нэмэлтээр ирсэн хүч хэрэгслийг удирдлагаар хангаж ажиллана.

2.4.4. Гамшиг ослын нөхцөл байдал, цар хүрээ, голомтын бүсэд үүрэг гүйцэтгэх анги, салбар, салаа, бүлэг, тасгийн хүч хэрэгслийн тооноос хамаарч ажиллагааны удирдлагыг шаардлагатай тохиолдолд дээд шатны албан тушаалтан шилжүүлэн авч энэ тухай анги байгууллагын удирдлага, голомтын бүсэд үүрэг гүйцэтгэж буй бүрэлдэхүүнд мэдэгдэнэ.

2.5. Ерөнхий эргүүл, хариуцлагатай жижүүрийн үйл ажиллагаа

2.5.1. Баяр, амралтын үед болон шаардлагатай тохиолдолд харьяа салбар, нэгжийн бэлэн байдалд хяналт тавьж, удирдлага зохицуулалтаар хангах чиг үүрэгтэй ерөнхий эргүүл, хариуцлагатай жижүүрийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, харьяа салбар нэгжийн даргын шийдвэрээр томилж ажиллуулна.

2.5.2. Ерөнхий эргүүл, хариуцлагатай жижүүрт Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар, нэгж, тухайн өдөр үүрэг гүйцэтгэж буй жижүүрлэлтийн бүрэлдэхүүн шууд захирагдана.

2.5.3. Ерөнхий эргүүлийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, дэд дарга, хариуцлагатай жижүүрийг бүсийн төв, аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Онцгой байдлын газар, хэлтэс, харьяа анги, байгууллагын дарга, захирагч нар шууд удирдлагаар хангаж ажиллана.

2.6. Шуурхай удирдлага, зарлан мэдээлэл хариуцсан нэгжийн үйл ажиллагаа

2.6.1. Шуурхай удирдлага, зарлан мэдээлэл хариуцсан нэгж нь гамшгийн аюулыг зарлан мэдээлэх, Онцгой байдлын байгууллагын харьяа салбар нэгжийг гамшиг, аюулт үзэгдэл ослын үед шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах, удирдлагын холбоо зохион байгуулах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, холбогдох байгууллага, албан тушаалтантай мэдээлэл солилцох чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.6.2. Гамшиг, аюулт үзэгдэл ослын үед Онцгой байдлын ерөнхий газрын гал түймэр, гамшигтай тэмцэх бүтцийн нэгжийн дарга нар нэгжийн шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

Гуравдугаар бүлэг. Бэлэн байдал

3.1. Шуурхай ажиллагааны бэлэн байдал нь дараах зэрэгтэй байна.

3.1.1. албаны өдөр тутмын бэлэн байдал

3.1.2. албаны өндөржүүлсэн бэлэн байдал

3.2. Албаны өдөр тутмын бэлэн байдлын зэрэгт Онцгой байдлын ерөнхий

газрын харьяа салбар, нэгж нь томилгоот ээлжийн бүрэлдэхүүн, хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хэрэгсэл, нисдэг тэрэг, автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж, холбооны техник хэрэгсэл болон ар тал, нөөцийн бэлэн байдлыг хангаж, шуурхай үүрэг гүйцэтгэнэ.

3.3.Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүн үйл ажиллагаандаа өдөр тутмын бэлэн байдлыг хангаж ажиллана

3.4.Гамшгийн нөхцөл байдал үүссэн болон үүсэж болзошгүй нөхцөлд Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрээр албаны хэмжээнд, харьяа салбар, нэгжийн дарга, захирагч байгууллагын хэмжээнд албаны өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлнэ.

3.5.Албаны өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар, нэгж нь нийт хүч хэрэгсэл болон нөөцийн бэлэн байдлыг хангаж, шуурхай үүрэг гүйцэтгэнэ.

3.6.Албаны өдөр тутмын болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт Онцгой байдлын ерөнхий газрын удирдлага, зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх салбар нэгжийн дарга, захирагч хяналт тавьж ажиллана.

3.7.Шуурхай ажиллагааны бэлэн байдал нь дараах төрлүүдээр хангагдана.

3.7.1.бие бүрэлдэхүүний

3.7.2.холбоо, зарлан мэдээллийн

3.7.3.нисдэг тэрэг, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн

3.7.4.харилцан ажиллагааны

3.7.5.нөөц, хангалтын

3.8.Бие бүрэлдэхүүний бэлэн байдал нь гамшиг, аюулт үзэгдэл, ослоос эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах мэргэшил, мэдлэг, ур чадвар, дадлага туршлага, эрүүл мэнд, бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэлээр хангагдана.

3.9.Холбоо зарлан мэдээллийн бэлэн байдал нь бүх төрлийн холбоог зохион байгуулах, зарлан мэдээлэх техник тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, гамшгийн нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг шуурхай тасралтгүй хүлээн авах, дамжуулах үйл ажиллагаагаар хангагдана.

3.10.Нисдэг тэрэг, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдал нь гамшиг, ослын голомтод үүрэг гүйцэтгэх шатахуун, техникийн бүрэн бүтэн байдал болон хөдөлгөөний аюулгүй байдлаар хангагдана.

3.11.Харилцан ажиллагааны бэлэн байдал нь гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, аж ахуй нэгж байгууллага, иргэдтэй харилцан ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтаар хангагдана.

3.12.Нөөц хангалтын бэлэн байдал нь голомтод үүрэг гүйцэтгэх анги, салбар, бүлэгт шаардлагатай хоол, хүнс, хувцас, шатах тослох материал, техник, тоног төхөөрөмж, сэлбэг, аврах багаж хэрэгсэл, хүч хэрэгслийн нөөцийг бүрдүүлснээр хангагдана.

3.13.Шуурхай ажиллагааны бэлэн байдлыг хангах, ажиллагааг зохион байгуулахдаа бие бүрэлдэхүүний хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны холбогдох хууль, дүрэм, журам, зааврыг мөрдлөг болгож ажиллана.

Дөрөвдүгээр бүлэг. Шуурхай удирдлага,
зарлан мэдээллийн нэгжийн эрх, үүрэг

4.1.Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн нэгж нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллана:

4.1.1.онцгой байдлын байгууллагын бүсийн төв, нийслэл, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллага, тэдгээрийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн нэгжийг удирдлага, зохицуулалтаар хангах;

4.1.2.гамшгийн голомт, шуурхай бүлэг, Шуурхай штаб, Онцгой байдлын ерөнхий газрын удирдлагыг мэдээллээр хангах, удирдлагын холбоог зохион байгуулах;

4.1.3.холбогдох улс, бүс, орон нутаг, байгууллага, албан тушаалтанд мэдээлэл дамжуулах, шаардлагатай мэдээллийг гаргуулан авах, гамшгийн тухай мэдээ мэдээллийг энэхүү журмын 1, 14 дүгээр хавсралтад заасны дагуу солилцох;

4.1.4.гамшиг, аюулт үзэгдэл ослын нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээлэл хүлээн авах, дамжуулах, мэдэгдэх, танилцуулах, бүртгэх, удирдлагыг мэдээллээр хангах;

4.1.5.Онцгой байдлын ерөнхий газар, Улсын Онцгой комиссын Шуурхай штабын холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгсэл, нөөц цахилгаан үүсгүүр, системийн болон бусад тоног төхөөрөмж, программ хангамж, сервер, сүлжээний бэлэн байдлыг хангах;

4.1.6.гамшгийн аюулыг зарлан мэдээлэх, онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүнд зарлан мэдээллийн дохиог энэхүү журмын 8, 9, 10 дугаар хавсралтуудад заасны дагуу дамжуулах;

4.1.7.холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, зарлан мэдээллийн хөдөлгөөнт удирдлагын төв, хөдөлгөөнт холбооны зангилаа, хөдөлгөөнт удирдлагын автомашины бэлэн байдлыг хангах, засвар үйлчилгээ батлагдсан төсвийн хүрээнд хийх;

4.1.8.гамшгийн цар хүрээ, нөхцөл байдалтай уялдуулан шаардлагатай тохиолдолд шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч, холбоо зарлан мэдээлэл хариуцсан операторыг хүч нэмэгдүүлэн ажиллуулах;

4.1.9.хөдөлгөөнт удирдлагын автомашин, зарлан мэдээллийн хөдөлгөөнт удирдлагын төв, хөдөлгөөнт холбооны зангилгааг харуул хамгаалалт бүхий дулаан тавиуланд байрлуулах;

4.1.10.шуурхай бүлгийн албан томилолтын үнэмлэх, холбооны техник хэрэгсэл, холбогдох зардал (автомашины шатахуун, бэлэн мөнгө)-ыг бэлэн байлгаж, нөхөн бүрдүүлэх;

4.1.11.бүсийн төв, онцгой байдлын газар, хэлтэс, харьяа анги салбарын шуурхай удирдлага, зарлан мэдээлэх нэгж нь энэхүү журмын 4.1.1-4.1.4, 4.1.6-д заасныг хэрэгжүүлж ажиллана.

4.2.Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч нь дараах эрхийг хэрэгжүүлж ажиллана:

4.2.1.гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээ, мэдээллийг хүлээн авч, нөхцөл байдлыг үнэлэн, шийдвэр гаргах, шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах, харилцан ажиллагааг зохицуулах, хяналт тавих, энэ тухай Онцгой байдлын ерөнхий газрын удирдлагад тухай бүрт нь илтгэх;

4.2.2.онцгой байдлын байгууллагын томилгоот бүрэлдэхүүнд шуурхай удирдлага, зохицуулалтын асуудлаар утсаар болон цахим дүрст холболтоор үүрэг, чиглэл өгөх, хяналт тавих;

4.2.3.шаардлагатай тохиолдолд Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжүүд, Гамшгаас хамгаалах албадаас хүч хэрэгсэл гаргаж ажиллуулах;

4.2.4.удирдлагаас өгсөн үүргийг холбогдох байгууллага, албан тушаалтанд дамжуулах, биелэлтэд нь хяналт тавих, шаардлагатай мэдээллийг гаргуулан авах;

4.2.5.удирдлагын шийдвэрийн дагуу Онцгой байдлын ерөнхий газар, харьяа салбар нэгжийн бие бүрэлдэхүүнд "Яаралтай цуглар" дохио өгч, цугларалтын байдалд хяналт тавьж, ирцийг хүлээн авч, танилцуулах;

4.2.6.төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллага, иргэн, хуулийн этгээдээс шаардлагатай мэдээ, мэдээлэл, хүч хэрэгслийн тооцоо, судалгааг гаргуулан авах;

4.2.7.гамшгийн үед бүх төрлийн утсан холбоо тасарсан нөхцөлд биет холбоочин томилж ажиллуулах;

4.3.Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч дараах үүргийг хэрэгжүүлж ажиллана:

4.3.1.гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүнтэй тасралтгүй холбоо тогтоож, үүссэн нөхцөл байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, дэд дарга, УОК-ийн нарийн бичгийн дарга, гал түймэр, гамшгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж болон шуурхай удирдлага, зарлан мэдээллийн нэгжийн дарга нарт танилцуулж, удирдлагаас өгсөн үүргийг холбогдох албан тушаалтанд мэдэгдэх;

4.3.2.гамшгийн нөхцөл байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай удирдлагын нэгдсэн төв, Засгийн газрын Шуурхай жижүүр, Тагнуулын ерөнхий газрын ерөнхий зохицуулагчид тогтоосон цагт болон тухай бүр мэдээлж, бүх шатны шуурхай штабтай мэдээлэл солилцох;

4.3.3.амралт, нийтээр амрах баярын өдөр, ажлын бус цагаар албан томилолтын үнэмлэх, зардал (зам хоног, байрны зардал, автомашины шатахуун олгож, санхүүтэй)-ын тооцоо хийх;

4.3.4.агаарын хөлгийн нислэг үйлдэх шийдвэр "Нислэг үйлдэх удирдамж"-ийг Агаараас эрэн хайх, аврах ангид дамжуулах (нислэг үйлдэх удирдамж, нислэг захиалах албан бичгийг Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газраас боловсруулж, нислэг үйлдэх шийдвэр гаргасан албан тушаалтнаар батлуулна);

4.3.5.нислэг үйлдэх шийдвэр, нислэгийн зорилго, чиглэлийг агаараас эрэн хайх, аврах ангийн захирагч болон нислэг төлөвлөлт, навигацийн мэргэжилтэнд мэдэгдэх;

4.3.6.нислэгийн мэдээлэл (агаарын хөлгийн ниссэн цаг, чиглэл, буусан цаг, байршил болон бусад шаардлагатай нэмэлт мэдээлэл)-ийг Агаараас эрэн хайх, аврах ангийн нислэг төлөвлөлт, навигацийн мэргэжилтнээс тогтмол хүлээн авч, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Тэргүүн дэд бөгөөд штабын дарга, дэд дарга, Ажиллагааны удирдлагын газар, Гал түймэртэй тэмцэх газрын даргыг мэдээллээр хангах;

4.3.7.нийслэлийн бүсэд нисдэг тэрэг хөөрөх, буух тохиолдолд тухайн талбайг эзэмшигч байгууллагуудад урьдчилан мэдэгдэж, аюулгүй байдлыг хангуулах;

4.3.8.зайлшгүй шалтгаанаар нислэгийн зорилго, чиглэлийг өөрчилсөн шийдвэрийг ангийн нислэг төлөвлөлт, навигацийн мэргэжилтэнд дамжуулах;

4.3.9.гамшиг, ослын голомтод үүрэг гүйцэтгэж буй эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчийг мэдээллээр хангах, хууль хяналтын, эрүүл мэндийн болон бусад байгууллагатай хамтран ажиллах, мэдээллийг дамжуулах, тэдгээрээс дэмжлэг, туслалцаа авах;

4.3.10.гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллагыг шуурхай удирдлагаар хангах, харилцан ажиллагаа, гамшгаас хамгаалах албаны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

4.3.11.гамшгийн зарлан мэдээлэл явуулах үүргийг техникийн бэлэн байдал хариуцсан инженер, холбоо зарлан мэдээлэл хариуцсан операторт өгч, хяналт тавьж ажиллах;

4.3.12.гамшгийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл, хэрэгжүүлсэн арга хэмжээ, дүгнэлтийг Гамшгийн нөхцөл байдлын хоногийн мэдээнд бүрэн тусгаж, цахим системд оруулах;

4.3.13.гамшгийн нөхцөл байдлын хоногийн мэдээг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Тэргүүн дэд бөгөөд Штабын дарга, дэд дарга, Ажиллагааны

удирдлага болон Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан бүтцийн нэгжийн дарга, Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн даргад танилцуулах, удирдлагаас өгсөн үүргийг холбогдох албан тушаалтанд мэдэгдэх;

4.3.14.энэхүү журмын 2 дугаар хавсралтад заагдсан бүртгэлийг хөтлөх;

4.4.Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч нь энэхүү журмын 4.2, 4.3-т заасан эрх, үүргээс гадна гамшгийн төрлүүдэд дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана:

4.4.1.Газар хөдлөлтийн үед

4.4.1.1.зарлан мэдээлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

4.4.1.2.газар хөдлөлт болсон тухай мэдээллийг Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 92 дугаар тушаалын 3 дугаар хавсралтад заагдсан албан тушаалтан нарт мэдэгдэж хэрэгжилтэд нь хяналт тавих, биелэлтийн талаар хариу мэдэгдэх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай удирдлагын нэгдсэн төв, Засгийн газрын Шуурхай жижүүрт мэдэгдэх;

4.4.1.3.газар хөдлөлтөд өртсөн бүс нутаг, хамарсан хүрээ, хүчийг Одон орон, геофизикийн хүрээлэнгээс тодотгон, цагийн байдлыг удирдлагад илтгэх;

4.4.1.4.эрэн хайх, аврах ажиллагаанд оролцож байгаа хүч хэрэгсэл, бүх шатны онцгой комиссын шуурхай штабтай байнгын мэдээлэл солилцон, удирдлага зохион байгуулалт, чиглэлээр хангаж ажиллах;

4.4.1.5.шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

4.4.2.Их цас, зуд, хүчтэй салхи, цасан болон шороон шуурганы үед

4.4.2.1.цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээнд тулгуурлан үнэлгээ, дүгнэлт хийх, орон нутагт хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай мэдээллийг авч, чиглэл өгөх;

4.4.2.2.“Дохио”, “Харанга” сэрэмжлүүлгийг Ус цаг уур, орчны шинжилгээний газраас тодруулж, бүсийн төв, орон нутгийн онцгой байдлын байгууллага, хүн амд зарлан мэдээлэх;

4.4.2.3.их цас, зуд, хүчтэй салхи, цасан болон шороон шуурга болсон нутгийн зааг, хэмжээ, өртсөн айл өрх, хүн, мал, амьтан, эд хөрөнгийн тухай мэдээллийг нэгтгэх;

4.4.2.4.төөрсөн буюу сураггүй болсон хүнийг эрэн хайх аврах ажиллагааны явц, үр дүнг тодруулах;

4.4.2.5.шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

4.4.3.Үер, усны аюулын үед

4.4.3.1.гамшгийн аюулыг зарлан мэдээлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

4.4.3.2.үер, усны аюулд автагдсан нутаг дэвсгэрийг тойм зурагт тэмдэглэж, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсээс нөхцөл байдлыг тодотгох, хэрэгжүүлж байгаа арга хэмжээг удирдлагад танилцуулах;

4.4.3.3.үерт автагдсан нутаг дэвсгэрээс хүн, мал, эд хөрөнгө, музейн үзмэр, түүх, соёлын биет өвийг нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд харьяа анги, салбар, холбогдох байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг татан оролцуулах;

4.4.3.4.ажлын явц, үр дүн, хохирлын мэдээг нэгтгэж, цаашид авах арга хэмжээ, тулгамдсан асуудлыг хоногийн мэдээнд тусгаж удирдлагад танилцуулах;

4.4.3.5. шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

4.4.4.Хүн, мал, амьтны гоц халдварт өвчний үед

4.4.4.1.аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт хүн, мал, амьтны гоц халдварт өвчний сэжиг илэрсэн тухай мэдээллийг холбогдох гамшгаас хамгаалах албадад мэдэгдэх, мэргэжлийн байгууллагын үүрэг зөвлөмж гаргуулах;

4.4.4.2.халдварын голомт бүхий бүс нутагт хорио цээрийн дэглэм, хавьтлыг тогтоох, тусгаарлах, эмчлэх болон бусад арга хэмжээ, хүн, мал, тээврийн

хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлалт, нийслэл, орон нутгийн удирдлагаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд хяналт тавих;

4.4.4.3.зэргэлдээ аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэст гоц халдварт өвчний сэжиг илэрсэн тухай мэдээлж, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг тодруулж, үүрэг чиглэл өгөх;

4.4.4.4.төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдээс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай мэдээллийг гаргуулан авах;

4.4.4.5.шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

4.4.5.Ой, хээрийн гал түймэр гарсан үед

4.4.5.1.БНХАУ, ОХУ-ын холбогдох байгууллагад хил орчмын ой, хээрийн гал түймрийн мэдээ, мэдээллийг энэхүү журмын 14 дүгээр хавсралтад заасны дагуу мэдэгдэх;

4.4.5.2.гамшгийн аюулыг зарлан мэдээлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

4.4.5.3.ой, хээрийн гал түймрийн мэдээг хүлээн авч, цаг агаар, газар орны нөхцөл байдалд үнэлгээ өгч, тойм зурагт тэмдэглэх;

4.4.5.4.ой, хээрийн гал түймэр гарч байгаа аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Онцгой байдлын газар, хэлтсээс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, ажиллаж байгаа хүч хэрэгслийн мэдээг тодруулж, дүгнэлт хийх, чиглэл өгөх;

4.4.5.5.ой, хээрийн гал түймэрт өртөж болзошгүй хүн, мал, өвс тэжээл, хашаа саравч байгаа эсэхийг тодотгож, аймаг, сумдын удирдлага болон холбогдох байгууллагад мэдэгдэж, арга хэмжээг зохион байгуулах талаар удирдлагаас өгсөн үүргийг тухайн аймгийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга нарт хүргэж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

4.4.5.6.хоногийн нөхцөл байдлын мэдээг тойм зурагт оруулан удирдлагад танилцуулах;

4.4.5.7.шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

4.4.6.Хүн ам төвлөрсөн хот суурин газарт удаан хугацаагаар үргэлжилсэн гал түймэр гарсан үед

4.4.6.1.гал түймэр гарсан тухай мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Тэргүүн дэд бөгөөд штабын дарга, дэд дарга нар, бүтцийн нэгж болон шуурхай удирдлага, зохицуулалтын нэгжийн дарга, холбогдох албан тушаалтан (мэргэжилтэн)-д илтгэж, өгсөн үүргийг гүйцэтгэгчид мэдэгдэж хэрэгжилтэд нь хяналт тавих, биелэлтийн талаар хариу мэдэгдэх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай удирдлагын нэгдсэн төв, Засгийн газрын Шуурхай жижүүрт мэдэгдэх;

4.4.6.2.гал түймэр унтраах үйл ажиллагаа болон гал түймрийн нөхцөл байдалд үнэлгээ өгч, аврах, гал түймэр унтраах анги, салбар бүлгүүдийг ажиллуулж, үүрэг гүйцэтгэлд нь хяналт тавих;

4.4.6.3.гамшгийн аюулыг зарлан мэдээлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

4.4.6.4.нутгийн захиргааны байгууллага болон түймэр гарсан газрын харьяалах дээд байгууллагаас мэдээлэл авч нөхцөл байдлыг тодруулах;

4.4.6.5.гал түймэрт өртсөн хүн, мал, амьтан, ургамал, эд хөрөнгийн хохирлын тухай мэдээллийг нэгтгэх;

4.4.6.6.гал түймрийг унтраах үйл ажиллагаанд шаардагдах нэмэлт хүч, хэрэгсэл, гал унтраах усны эх үүсвэрийн найдвартай байдал, хангалт үйлчилгээний талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах;

4.4.6.7.гал түймэр гарсан нутаг дэвсгэрт хүн, автомашины хөдөлгөөнийг хязгаарлах, гал түймэр гарсан шалтгаан нөхцөлийг тогтоолгохоор хууль хяналтын байгууллагад мэдэгдэх, мөрдөн байцаагч, галын шинжээч зэрэг мэргэжлийн ажилтнуудыг татан оролцуулах;

4.4.6.8. ажлын явц, үр дүнг нэгтгэж, цаашид авах арга хэмжээний тухай хоногийн мэдээнд тусгаж, удирдлагад илтгэх;

4.4.6.9. шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

4.4.7. Үйлдвэрлэлийн болон зам, тээврийн хэрэгслийн осол сүйрлийн үед

4.4.7.1. үйлдвэрлэлийн болон тээврийн хэрэгслийн осол, сүйрэл болсон тухай мэдээллийг холбогдох улсын албад, албан тушаалтанд мэдээлэх;

4.4.7.2. осол, сүйрэл болсон газрын нөхцөл байдлыг тодотгох, осол сүйрлийн хохирлын урьдчилсан мэдээллийг холбогдох улсын албадаас авч нэгтгэх;

4.4.7.3. осол, сүйрлийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс, мэргэжлийн албадыг татан оролцуулах, аврах ажилд шаардагдах хүн хүч, техник багаж хэрэгслээр хангах ажлыг тодотгох, улсын албадыг оролцуулах;

4.4.7.4. нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох, зам, гүүр, төмөр зам, онгоцны буудлын хэвийн үйл ажиллагааны талаар холбогдох арга хэмжээг удирдлага зохицуулалтаар хангах;

4.4.7.5. аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлын явц, үр дүнг нэгтгэж, хоногийн нөхцөл байдлын мэдээнд тусгаж, удирдлагад илтгэх;

4.4.7.6. шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

4.4.8. Цацраг, химийн хорт бодис алдагдсан үед

4.4.8.1. ослын голомтод ажиллаж байгаа цацраг, химийн хорт бодисыг илрүүлэх, хоргүйжүүлэх аргачлалыг тодотгох, цацраг химийн хордолтыг саармагжуулах үүрэг бүхий цацраг, химийн шинжилгээний шуурхай бүлэгтэй байнгын холбоонд орж мэдээ, мэдээлэл солилцох, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

4.4.8.2. гамшгийн аюулыг зарлан мэдээлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

4.4.8.3. цагийн байдалд үнэлгээ хийхэд цаг уурын байдлыг харгалзах, хордолт тархах гүн, эзлэх талбай, хил хязгаарыг тодорхойлох, хүн амын байршил, нягтралыг тогтоож тойм зурагт тэмдэглэх;

4.4.8.4. цацраг, химийн хордолтын цагийн байдалд урьдчилсан үнэлгээ хийж, болзошгүй хордолтын бүсийн хэмжээ, цаашид тархаж болзошгүй газар нутгийн хил хязгаар, хүн амын байршил, нягтралыг урьдчилсан байдлаар тогтоох;

4.4.8.5. шаардлагатай хүч хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, бодис, уусмалын нөхөн хангалтад тодотгол хийх;

4.4.8.6. цацраг, химийн хордолтын хор уршгийг арилгах ажлын явц, үр дүнг нэгтгэн цаашид авах арга хэмжээний тухай хоногийн нөхцөл байдлын мэдээнд тусгаж, тойм зургийн хамт удирдлагад илтгэх;

4.4.8.7. шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

4.4.9. Тэсэрч, дэлбэрэх бодисын ослын үед

4.4.9.1. Зэвсэгт хүчин болон хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар, нэгжийг тусгай зааврын дагуу бэлэн байдалд оруулах, харуул хамгаалалтыг хүч нэмэгдүүлэх, үүрэг, зөвлөмж өгөх;

4.4.9.2. тэсэрч, дэлбэрэх бодисын ослын нөхцөл байдлыг тодотгох, дэлбэрэлтийн хамарсан хүрээ, хохирлын урьдчилсан мэдээллийг авах, нөхцөл байдлыг удирдлагад илтгэж, өгсөн үүргийг дамжуулж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

4.4.9.3. тэсэрч, дэлбэрэх бодисын хор уршгийг арилгах үйл ажиллагаанд Зэвсэгт хүчин, хууль сахиулах байгууллагууд, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн хүч хэрэгсэл, мэргэжлийн албадыг татан оролцуулах;

4.4.9.4. төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдээс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай мэдээллийг нэгтгэх;

4.4.9.5.нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох, зам, гүүр, төмөр зам, онгоцны буудал зэрэг дэд бүтэц барилга байгууламжийн аюулгүй ажиллагааг хангах талаар холбогдох байгууллагаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үр дүнгийн талаарх мэдээллийг авч нэгтгэх;

4.4.9.6.аврах, хор уршгийг арилгах ажлын явц, үр дүнг нэгтгэж, цаашид авах арга хэмжээний тухай хоногийн нөхцөл байдлын тухай мэдээнд тусгаж танилцуулах;

4.4.9.7.шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4.4.9.8.бүсийн төвийн шуурхай удирдлагын зохицуулагч нь энэхүү журмын 4.3, 4.4-т зааснаас өөрийн чиг үүрэгт хамааралтай эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллах.

4.5.Техникийн бэлэн байдал хариуцсан инженер нь дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана:

4.5.1.онцгой байдлын байгууллагын бүсийн төв, нийслэл, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллагын шуурхай удирдлага, зарлан мэдээллийн нэгжийн холбоо зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтнийг удирдлагаар ханган, техникийн бэлэн байдлын талаар үүрэг чиглэл өгөх;

4.5.2.зарлан мэдээллийн системд холбогдсон байгууллагаас ирүүлсэн мэдээ мэдээллийг шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчид тухай бүр танилцуулах, журмын дагуу зарлан мэдээлэх;

4.5.3.холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгсэл, программ хангамж, шуурхай штабын холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгсэл, Зарлан мэдээллийн системийн сүлжээний бэлэн байдлыг хангах;

4.5.4.шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн өгсөн үүрэг, баталсан хуваарь, бичвэрийн дагуу гамшгийн аюулын зарлан мэдээлэл явуулах;

4.5.5.үүрэг гүйцэтгэсэн хугацаанд хийсэн ажлын тухай мэдээг нэгжийн дарга, орлогчид биечлэн танилцуулж ажлаа хүлээлцэх;

4.5.6.зарлан мэдээлэх үйл ажиллагааг удирдлагын байрнаас хийх боломжгүй тохиолдолд зарлан мэдээллийн хөдөлгөөнт удирдлагын төвийг ажиллагааны бэлэн байдалд оруулж удирдлагыг автоматаар шилжүүлэн зарлан мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

4.5.7.шуурхай штабын холбооны техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулж ажиллах;

4.5.8.шаардлагатай тохиолдолд холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслийг Онцгой байдлын ерөнхий газар, харьяа салбар нэгжээс татан төвлөрүүлэх, хуваарилах, ажиллуулах;

4.5.9.гамшгийн үед үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран холбоо зохион байгуулах, мэдээ мэдээлэл солилцох, бүртгэх, холбогдох албан тушаалтанд танилцуулах;

4.5.10.холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгсэл, программ хангамж, шуурхай штабын холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгсэл, Зарлан мэдээллийн системийн сүлжээнд гарсан гэмтлийг даруй засварлах;

4.5.11.Одон орон геофизикийн хүрээлэн, Цаг уур орчны шинжилгээний газартай Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Одон орон геофизикийн хүрээлэнгийн захирал, Цаг уур орчны шинжилгээний газрын дарга нарын 2016 онд хамтран баталсан "Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх, систем хоорондын харилцан ажиллагааг зохицуулах журам"-ын дагуу мэдээлэл солилцох;

4.5.12.газар хөдлөлтийн тухай мэдээ мэдээллийг Монгол Улсын Шадар сайдын баталсан 2022 оны 92 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу иргэдэд мэдээлэх;

4.5.13.Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын дагуу "И-Монголиа аппликейшн" ашиглан газар хөдлөлтийн мэдээлэл үнэн зөв, алдаагүй иргэдэд дамжуулах.

4.6. Холбоо зарлан мэдээлэл хариуцсан оператор нь дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана:

4.6.1. онцгой байдлын байгууллагын бүсийн төв, нийслэл, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллагын шуурхай удирдлага, зарлан мэдээллийн нэгжийн дуудлага хүлээн авагчийг удирдлагаар ханган, мэдээ мэдээлэл гаргуулан авах;

4.6.2. Онцгой байдлын ерөнхий газар, харьяа, салбар нэгжээс болон гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа шуурхай бүлэгтэй бүх төрөл (радио, телефон, сансрын, цахим, дүрст, хөдөлгөөнт)-ийн холбоог зохион байгуулах, бүртгэх, холбогдох албан тушаалтанд танилцуулах;

4.6.3. гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчид танилцуулах;

4.6.4. гамшгийн зарлан мэдээллийг шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн өгсөн үүрэг баталсан хуваарь, бичвэрийн дагуу эфирээр нэвтрүүлэх;

4.6.5. зарлан мэдээлэл дамжуулсан тухай бүртгэл хөтлөх, холбогдох албан тушаалтанд танилцуулах;

4.6.6. шуурхай бүлэгт шаардлагатай албан томилолын үнэмлэх, бэлэн мөнгө, автомашины шатахууны талон, суурин болон үүрэн телефон холбооны ярианы төлбөрийн карт, сансрын холбооны утас, хэт богино долгионы гар радио станц, богино долгионы станцууд, байршил тодорхойлогчийг журамд заасны дагуу олгох, хүлээлцэх, бэлэн байдлыг хангуулах;

4.6.7. үүрэг гүйцэтгэсэн хугацаанд хийсэн ажлын тухай хоногийн мэдээг нэгжийн дарга, орлогчид биечлэн танилцуулж ажлаа хүлээлцэх;

4.6.8. гамшиг осол, аюулт үзэгдэл, ослын мэдээ, мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс хүлээн авах;

4.6.9. гамшиг осол, аюулт үзэгдэл, ослын мэдээ, мэдээллийг батлагдсан маягтын дагуу "Цахим систем"-д оруулах, харьяа салбар нэгжүүдийн дуудлага хүлээн авагч нарын мэдээ оруулж буйд хяналт тавих;

4.6.10. гамшгийн үед "Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүнд энэхүү журмын 8, 9, 10 дугаар хавсралтад заасны дагуу зарлан мэдээллийн дохио өгөх;

4.6.11. Онцгой байдлын ерөнхий газар, харьяа салбар нэгж, Улсын онцгой комисс, УИХ, Засгийн газар, яам, тамгын газар, Гамшгаас хамгаалах албад, бусад холбогдох байгууллагын дарга, эрхлэгч, албан тушаалтнуудын утасны дугаарыг гаргуулан авах, тодотгох;

4.6.12. газар хөдлөлтийн тухай мэдээ мэдээллийг Монгол Улсын Шадар сайдын баталсан 2022 оны 92 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу багц мессеж хүргэх, баримтжуулах, нэгжийн даргад танилцуулах;

4.6.13. энэхүү журмын 2 дугаар хавсралтад заагдсан бүртгэлийг хөтлөх;

4.6.14. Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх салбар, нэгжийн дуудлага хүлээн авагч нь энэхүү журмын 4.6-д зааснаас өөрийн чиг үүрэгт хамаарах үүргийг хэрэгжүүлж ажиллах.

4.7. Зарлан мэдээлэх үйл ажиллагаа

4.7.1. Зарлан мэдээлэх үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн аюулын тухай Зарлан мэдээллийн дохио дамжуулах журам", Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх үйл ажиллагааны MNS 6980:2022 стандарт, Шадар сайдын 2022 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Газар хөдлөлтийн тухай мэдээ мэдээллийг дамжуулах журам", мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн зарлан мэдээллийг зохион байгуулна.

4.7.2. Зарлан мэдээлэх, холбооны техник хэрэгсэл, программ хангамжийн гэмтэл, саатлын улмаас гамшгийн аюулыг зарлан мэдээлэх боломжгүй болсон

тохиолдолд зарлан мэдээллийн хөдөлгөөнт удирдлагын төв, хөдөлгөөнт холбооны зангилгааг ашиглан орон нутаг, объект, голомтын бүсэд шуурхай шилжин байрлаж зарлан мэдээллийг дамжуулна.

4.7.3.Гамшгийн аюулын зарлан мэдээллийг дараах түвшинд ангилж зохион байгуулна:

4.7.3.1."улаан" түвшин нь гамшгийн нөхцөл байдал үүсэж хүн амд аюулгүй байдлаа хангах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх, аюулгүй газарт шилжин очихыг мэдэгдэж буй хэлбэр бөгөөд зарлан мэдээллийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, түүний эзгүй тохиолдолд Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрээр зохион байгуулна.

4.7.3.2."улбар шар" түвшин нь гамшгийн онцгой нөхцөл байдал үүсэж хүн амд аюулгүй байдлаа хангах арга хэмжээг авахыг мэдэгдэж буй хэлбэр бөгөөд зарлан мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрээр зохион байгуулна.

4.7.3.3."шар" түвшин нь аюултай нөхцөл байдал үүсэж хүн амд аюулгүй байдлаа хангах арга хэмжээг авахыг мэдэгдэж буй хэлбэр бөгөөд зарлан мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх нэгжийн даргын шийдвэрээр зохион байгуулна.

4.7.3.4.аймаг, сумын хэмжээнд Онцгой комиссын даргын шийдвэрээр улаан, улбар шар, шар түвшний зарлан мэдээллийг зохион байгуулна.

4.7.4.Гамшгийн аюулын зарлан мэдээллийн шалгуур үзүүлэлт:

д/д	Аюулт үзэгдэл, ослын төрөл	Түвшинд харгалзах шалгуур үзүүлэлт		
		Улаан түвшин	Улбар шар	Шар
1.	Газар хөдлөлт	Одон орон геофизикийн хүрээлэнгээс тооцоолж ирүүлсэн мэдээ 6.1М-аас дээш тохиолдолд	Одон орон геофизикийн хүрээлэнгээс тооцоолж ирүүлсэн мэдээ 5.6-6.0М-аас дээш тохиолдолд	Одон орон геофизикийн хүрээлэнгээс тооцоолж ирүүлсэн мэдээ 5.0-5.5М-аас дээш тохиолдолд
2.	Хүчтэй салхи	Салхины дундаж хурд ойт хээр, уулархаг нутагт 24 м/с, тал хээр, говь цөлийн бүсэд 28 м/с, түүнээс их (өрөвхийлэлтийн хурд 34 м/с болон түүнээс их) Хугацаа хамаарахгүй	Салхины дундаж хурд 18 м/с, түүнээс их (өрөвхийлэлт 24 м/с түүнээс их) Хугацаа хамаарахгүй	Салхины дундаж хурд 10 м/с ба түүнээс их, өрөвхийлөлт 20-23 м/с хүрэх бөгөөд салхины дундаж их хурд хүрэх үед
3.	Шороон шуурга		Алсын барааны харагдац 1000 метр болон түүнээс бага болох 3 цаг, түүнээс дээш	Салхины дундаж хурд 10-15 м/с, алсын барааны харагдац 10 км-ээс бага болж шороон шуурга шуурах, цаашдаа урьдчилан сэргийлэх мэдээ өгөх хэмжээнд хүрч болзошгүй үед
4.	Цасан шуурга	Салхины дундаж хурд 16 м/с (өрөвхийлэлт 20 м/с болон түүнээс их, алсын бараа 2000 м-ээс бага болох 6 цаг, түүнээс дээш	Салхины дундаж хурд 10 м/с болон түүнээс их үед цасан шуурга шуурч алсын бараа 2000 м-ээс бага болох 3 цаг, түүнээс дээш	Цасан шуурга шуурах, цаашдаа урьдчилан сэргийлэх мэдээ өгөх хэмжээнд хүрч болзошгүй үед
5.	Бороо	50 мм их 12 доош болон түүнээс цаг, түүнээс	30 мм болон түүнээс их 12 цаг, түүнээс доош	

6.	Аадар бороо	30 мм их 1 доош болон түүнээс цаг, түүнээс	30 мм болон түүнээс их 3 цаг, түүнээс доош	Сь уул 60 км радиус дотор орж ирэх, радар дээр тунадасны эрчимшил 25 мм/цагаас их, радиолокацын ойлт 45 дцб-ээс их болоход Радартай газар нутгуудад нөхцөл бүрдэхээс 21 цагийн өмнө
7.	Хүйтэн бороо	Агаарын температур 8°C болон түүнээс бага, салхины хурд 6 м/с болон түүнээс их уед 5 мм-ээс их бороо үргэлжлэн орох 12 цаг, түүнээс дээш	Агаарын температур 11 °с ба түүнээс бага, салхины хурд 6 м/с болон түүнээс их 12 цаг, түүнээс дээш	6 дугаар сарын эхнээс 7 дугаар сарын эхэн хүртэл хугацаанд бороо 12 цагаас удаан хугацаагаар үргэлжилж орох нөхцөл бүрдвэл
8.	Усны үер	Гол, мөрний ус эргээсээ халих буюу аюултай түвшинд хурэх /Хугацаа хамаарахгүй/	Гол, мөрний ус үерийн түвшинд хурэх [Хугацаа хамаарахгүй/	
9.	Уруйн үер	Хүчтэй аадар борооны ус гуу жалга, хэвгий даган шавар, шороо, чулуутай холилдож хуйлран урсах [Хугацаа хамаарахгүй/		
10.	Мөндөр	Голч нь 10 мм болон түүнээс их (хугацаа хамаарахгүй)	Голч нь 10 мм хүртэл (хугацаа хамаарахгүй)	Сь уул 60 км радиус дотор орж ирэх, радар дээр тунадасны эрчимшил 25 мм/цагаас их, радиолокацын ойлт 45 дцб-ээс их болоход Радартай газар нутгуудад нөхцөл бүрдэхээс 21 цагийн өмнө/
11.	Цочир хүйтрэлт (Таримлын ургалтын хугацаанд)	Хөрсний гадаргын температур -50с болон түүнээс бага /(хугацаа хамаарахгүй)	Хөрсний гадаргын температур 0°C болон түүнээс бага /хугацаа хамаарахгүй/	
12.	Их хүйтэн болох		Агаарын хамгийн бага температур Идэр, тэс, Завхан голын хөндий, Увс нуур, Дархадын хотгороор -500С, Алтайн өвөр говь, говийн нутгийн өмнөд хэсгээр -35°C, нутгийн өмнөд хэсгээр -35°C, бусад нутгаар -40°C-аас доош хүйтрэх (хугацаа хамаарахгүй)	

13	Цас, нойтон цас (10-3 дугаар сард)	10 мм болон түүнээс их 12 цаг, түүнээс доош	5 мм болон түүнээс их 12 цаг, түүнээс доош	12 цагийн дотор 2 мм-ээс их цас, нойтон цас орох боловч урьдчилан сэргийлэх мэдээ өгөх хэмжээнд
14.	Зуд	Өвөл бэлчээрийн цасны нягт нь аль ч бус нутагт 0.25 г/см^3 буюу түүнээс их, арав хоног, сарын дундаж агаарын температур олон жилийн дунджаас 3.0°C болон түүнээс хүйтэн, цасны дундаж зузаан өндөр уулын болон ойт хээрийн бүсэд 25 см-ээс, хээрийн бүсэд 22 см-ээс, говь цөлийн бүсэд 12 см-ээс их байх; Зун нь гантай, гандуу байсан нутагт өвөл цас ороогүй, арав хоног, сарын дундаж агаарын температур олон жилийн дунджаас 30°C болон түүнээс хүйтэн, мал ус, тэжээлээр дутагдах; Цаг зуурын дулааралт, хүйтрэлтийн улмаас цасны өнгөн хэсэг буюу гүнд мөсөн бүрхэвч тогтсоноос мал бэлчээрлэх боломжгүй болсон, эсвэл цасны нягт 0.35 г/см^3 болон түүнээс их болсон байх.	Бэлчээрийн цасны нягт нь аль ч бусад $0.20-0.24 \text{ г/см}^3$, цасны дундаж зузаан өндөр уулын болон ойт хээрийн бүсэд 16 см-ээс, хээрийн бүсэд 11 см-ээс, говь, цөлийн бүсэд 5 см-ээс их байх Зун гантай, гандуу байсан нутагт өвөл цас бага орсон, арав хоног, сарын дундаж агаарын температур олон жилийн дунджаас 2.0°C болон түүнээс хүйтэн, мал тэжээл, усаар дутагдах.	
15.	Их халуун болох		Агаарын хамгийн их температур говийн нутгаар хээрийн бүсэд $+36^\circ\text{C}$, бусад нутгаар $+32^\circ\text{C}$ -аас давж халах (хугацаа хамаарахгүй)	
16.	Ган	Тухайн арав хоног, сард орсон хур тунадасны хэмжээ олон жилийн дунджаас 50 хувь болон түүнээс бага, мөн хугацаанд агаарын дундаж температур олон жилийн дунджаас	Тухайн арав хоног, сард орсон хур тунадасны хэмжээ олон жилийн дунджийн 51-80 хувь, хугацаанд агаарын дундаж температур олон жилийн дунджаас $1.0-1.9^\circ\text{C}$ -ээ их байх буюу	

		2.0°C болон түүнээс их буюу дундаж квадрат хазайцаас 2 дахин давсан байх нөхцөлийг хамруулна	дундаж квадрат хазайцаасаа давсан байх нөхцөлийг хамруулна	
17.	Ойн гал түймэр	Хуурайшилтын зэрэг IV буюу түймрийн эрсдэл нэн их байх үед, салхины дундаж хурд ойт хээр, уулархаг нутагт 24 м/с түүнээс их үед	Хуурайшилтын зэрэг III буюу түймрийн эрсдэл их байх үед, салхины дундаж хурд ойт хээр, уулархаг нутагт 15-20 м/с болон түүнээс их үед	Хуурайшилтын зэрэг I-II буюу түймрийн эрсдэл бага болон дунд байх үед, салхины дундаж хурд ойт хээр, уулархаг нутаг 10-15 м/с ба түүнээс их үед
18.	Хээрийн гал түймэр	Хуурайшилтын зэрэг IV буюу түймрийн эрсдэл нэн их байх үед, салхины дундаж хурд 24 м/с түүнээс их үед	Хуурайшилтын зэрэг III буюу түймрийн эрсдэл их байх үед, салхины дундаж хурд 15-20 м/с болон түүнээс их үед	Хуурайшилтын зэрэг I-II буюу түймрийн эрсдэл бага болон дунд байх үед, салхины дундаж хурд 10-15 м/с, шуурга шуурах
19.	Объектын гал түймэр	Газрын тос олборлох, боловсруулах үйлдвэр, дулааны цахилгаан станц, эрчим хүч, хий цэнэглэх станц, автомашин хийгээр цэнэглэх цэг, химийн болон хортой бодис ашигладаг үйлдвэрт гал түймэр тархан дэлгэрсэн	Хүн ам олноор цугларах олон нийтийн газар, өндөр барилга, байгууламж, шатах тослох материалын агуулах, гэр хороололд нэг дор 4-өөс дээш хашаа хороо дамжин гал түймэр тархан дэлгэрсэн (хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах нөхцөл байдал үүссэн)	Эрүүл мэндийн хэвтэн эмчлүүлэх нэгдсэн эмнэлэг, сургууль, цэцэрлэг, асрамжийн барилга, байгууламжид үйл ажиллагаа явагдаж байх үед гал түймэр тархан дэлгэрсэн (хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах нөхцөл байдал үүссэн)
20.	Хүний гоц халдварт өвчин	Ихээхэн хэмжээний эсвэл эрсдэл бүхий бүлгийн хүн амд ноцтой нөлөө үзүүлсэн хэвийн үйл ажиллагаа болон ажил үйлчилгээнд ноцтой тасалдал гарсан, нэмэлт хариу арга хэмжээ шаардлагатай ба тэдгээрийг хэрэгжүүлэхэд ихэнхэд нь бодитой зайлшгүй шаардлагатай, шийдвэр гаргагчид болон оролцогч талуудын ажиллагаанд хэрэгцээтэй нэмэлт зардал их хэмжээгээр нэмэгдсэн	Цөөн тооны эсвэл эрсдэл бүхий бүлгийн хүн амд гүнзгий нөлөө үзүүлсэн, хэвийн үйл ажиллагаа болон ажил үйлчилгээнд гүн тасалдал гарсан, олон тооны нэмэлт хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай ба тэдгээрийн заримыг хэрэгжүүлэхэд бодитой шаардлагатай, шийдвэр гаргагчид болон оролцогч талуудын үйл ажиллагаанд хэрэгцээтэй нэмэлт зардал илэрхий нэмэгдсэн	Хүн амын нэлээд хэсэг эсвэл эрсдэл бүхий бүлгийн хүн амд дунд зэргийн үзүүлсэн, хэвийн үйл ажиллагаа болон ажил үйлчилгээнд дунд зэрэг тасалдал гарсан, зарим нэмэлт хариу арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай ба тэдгээрийг хэрэгжүүлэх нөөц шаардлагатай болсон, хэрэгцээтэй нэмэлт хэрэгцээтэй нэмэлт зардал дундаж хэмжээнд нэмэгдсэн.
21.	Мал, амьтны гоц	2 буюу түүнээс дээш аймаг, нийслэлийн	2 буюу түүнээс дээш сум, дүүргийн нутаг	1 сум, дүүргийн нутаг дэвсгэрт өвчлөл

	халдварт өвчин	нутаг дэвсгэрт өвчлөл лабораторийн шинжилгээгээр батлагдсан тохиолдолд	дэвсгэрт өвчлөл лабораторийн шинжилгээгээр батлагдсан тохиолдолд	лабораторийн шинжилгээгээр батлагдсан тохиолдолд
22.	Цацрагийн осол	Хүн амын жилд авах цацрагийн тунгийн хэмжээ 20 мЗв-ээс хэтэрсэн	Хүн амын жилд авах цацрагийн тунгийн хэмжээ 5 мЗв-ээс хэтэрсэн	
23.	Химийн хорт бодисын осол	Алдагдсан химийн бодисын агаар дахь хэмжээ зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн (15 минут) Тэсрэх дээд хязгаараас хэтэрсэн	Алдагдсан химийн бодисын агаар дахь хэмжээ зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн (7 хоногийн дундаж утга)	
24.	Тэсрэлт, дэлбэрэлт	Дэлбэрэлтийн улмаас барилга, байгууламж бүрэн нурсан, гал түймэр гарсан, агаарын болон хөрсний бохирдол үүссэн үед	Дэлбэрэлтийн үед барилга, байгууламжийн аюулгүй байдал нь үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөлийг алдагдуулсан үед	

4.7.5.Зарлан мэдээллийн системийн дуут дохиоллын цамхгаар гамшгийн аюулын зарлан мэдээллийг шууд яриа, дохио, бичвэр, дуут мэдээлэл хэлбэрээр дамжуулах:

4.7.5.1."улаан" түвшний үед зарлан мэдээллийн дуут дохиоллын цамхгаар түгшүүрийн дохиог 30 секунд үргэлжлэх хугацаатай 1 удаа дуугаргасны дараа шууд яриа, цахим самбараар богино бичвэрээр мэдээллийг тодорхой давталттай хүргэнэ.

4.7.5.2."улбар шар" түвшний үед сэрэмжлүүлэх дохиог 30 секунд үргэлжлэх хугацаатай 1 удаа дуугаргасны дараа "Иргэдийн анхааралд, урьдчилан сэргийлэх мэдээний товч утга. Онцгой байдлын ерөнхий газар" гэсэн шууд яриа дамжуулж цахим самбараар богино бичвэрээр мэдээллийг тодорхой давталттай хүргэнэ.

4.7.5.3."шар" түвшний үед сэрэмжлүүлэх дохиог 30 секунд үргэлжлэх хугацаатай 1 удаа дуугаргасны дараа "Иргэдийн анхааралд, сэрэмжлүүлэх мэдээний товч утга. Онцгой байдлын ерөнхий газар" гэсэн шууд яриа дамжуулж цахим самбараар богино бичвэрээр мэдээллийг тодорхой давталттай хүргэнэ.

4.7.6.Зарлан мэдээлэх системд холбогдсон телевизээр гамшгийн аюулын зарлан мэдээлэл дамжуулах:

4.7.6.1.Зарлан мэдээлэх системд холбогдсон телевизийн тоног төхөөрөмжөөр гамшгийн аюулын зарлан мэдээллийг шууд яриа, дохио, бичвэр, дуут мэдээлэл хэлбэрээр үргэлжлэх хугацааг 5 минутаас хэтрүүлэхгүйгээр тодорхой давталттайгаар дамжуулна.

4.7.6.2."улаан" түвшний үед эфирт бүтэн дэлгэцээр зарлан мэдээллийг хүргэх ба дэвсгэрийн өнгө улаан, бичвэрийн үсгийн өнгө хар байна.

Улаан өнгөний код: RGB 255/0/0

Хар өнгөний код: RGB 0/0/0

4.7.6.3. "улбар шар" түвшний үед эфирт дэлгэцийн доод хэсэгт зурвасаар зарлан мэдээллийг хүргэх ба зурвасын дэвсгэр өнгө улбар шар, бичвэрийн үсгийн өнгө хар байна.

Улбар шар өнгөний код: RGB 255/80/0

Хар өнгөний код: RGB 0/0/0

4.7.6.4."шар" түвшний үед эфирт дэлгэцийн доод хэсэгт зурвасаар зарлан мэдээллийг хүргэх ба зурвасын дэвсгэр өнгө шар, бичвэрийн үсгийн өнгө хар байна.

Телевизүүдийн дэлгэцийн доогуур урсан гарах бичвэрийн урсан өнгөрөх хурд нь үзэгч уншиж гүйцэхүйц байна.

Шар өнгөний код: RGB 255/245/0

Хар өнгөний код: RGB 0/0/0

4.7.7.Зарлан мэдээлэх системд холбогдсон FM радиогоор гамшгийн аюулын зарлан мэдээлэл дамжуулах:

4.7.7.1. Зарлан мэдээлэх системд холбогдсон FM радиогоор гамшгийн аюулын зарлан мэдээлэл дамжуулахдаа "Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх үйл ажиллагааны стандарт"-ын А1 болон А2 дугаар хавсралтын дагуу дамжуулна.

4.7.8. Зарлан мэдээллийг дараах сүлжээгээр дамжуулан хүргэнэ:

- өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр,
- радио холбооны сүлжээгээр,
- сансрын холбооны сүлжээгээр,
- үүрэн холбооны сүлжээгээр,
- цахим мэдээллийн сүлжээгээр,
- дотоод зарлан мэдээллийн системээр,
- биет холбоочноор,
- тусгай дуут дохиололтой автомашин, хэрэгслээр,

Тавдугаар бүлэг. Гамшгийн үеийн холбоо зохион байгуулах үйл ажиллагаа

5.1.Гамшгийн аюул үүссэн буюу үүсэж болзошгүй нөхцөл байдлын үед шуурхай удирдлагын суурин (байнгын) болон хөдөлгөөнт зарлан мэдээллийн удирдлагын төв, хөдөлгөөнт холбооны зангилгааны бэлэн байдлыг хангаж байгууллагын салбар, нэгж болон бусад байгууллага хооронд мэдээ, мэдээллийг шуурхай солилцоно.

5.2.Онцгой байдлын ерөнхий газрын шуурхай удирдлага, зарлан мэдээллийн нэгж, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын анги, салбар, нэгжүүд нь харилцаа холбооны дараах төрлийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон суурин болон хөдөлгөөнт холбооны зангилаатай байна.

5.2.1.Телефон холбоо:

5.2.1.1.суурин холбоо (АТС),

5.2.2.Үүрэн холбоо,

5.2.3.Сансрын холбооны утас,

5.2.4.Радио холбоо (богино болон хэт богино долгион)

5.2.4.1.аналоги системийн радио станц,

5.2.4.2.тоон системийн радио станц,

5.2.5.Мэдээллийн сүлжээний дэд бүтэц:

5.2.5.1.төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ,

5.2.5.2.интернэтийн сүлжээ (газрын болон сансрын),

5.2.6.Мэдээллийн систем:

5.2.6.1.дүрст хурлын систем,

5.2.6.2.теле хяналтын систем,

5.2.6.3.(E-doc цахим оффисын систем) мэдээлэл солилцох систем,

5.2.6.4.гамшгийн орон зайн мэдээллийн систем,

5.2.6.5.гамшгийн статистик, хохирол хэрэгцээний нэгдсэн систем

5.2.7.Бусад төрлийн холбоо:

5.2.7.1. шуудан холбоо,

5.2.7.2. биет холбоочин,

5.2.7.3. нисгэгчгүй нисэх төхөөрөмж,

5.3.Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх салбар нэгж нь энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан холбоо, мэдээллийн техник хэрэгслийг бүрдүүлж бэлэн байдлыг хангана.

5.4.Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай "Онцгой нөхцөл бий болсон үед байгууллагуудын харилцан ажиллах ерөнхий төлөвлөгөө"-д тусгагдсаны дагуу холбоог зохион байгуулна.

5.5.Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх анги, салбар, салаа бүлэг, тасаг, Шуурхай бүлэгт холбоочныг томилж "Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын радио холбоо зохион байгуулах журам", "Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод радио холбоо зохион байгуулах заавар"-ын дагуу холбоог зохион байгуулна.

5.6.Гамшгийн голомтод газар орны онцлог, бүс нутаг дахь холбооны сүлжээний байдал, гамшиг, аюулт үзэгдлийн нөлөөллийг тооцсоны үндсэн дээр дараах үүргийн дагуу холбоог зохион байгуулна. Үүнд:

5.6.1.Удирдлагын болон харилцан ажиллагааны холбоог:

- богино болон хэт богино долгионы радио станц;
- сансрын холбооны утас;
- үүрэн холбооны утас;
- цахим холболтоор.

5.6.2.Бүлгийн болон зарлан мэдээллийн холбоог:

- богино болон хэт богино долгионы радио станц;
- чанга ярих хэрэгсэл;
- биет холбоочин;
- зөөврийн сүлжээ үүсгэх төхөөрөмж.

5.7.Холбооны хэрэгсэл, мэдээлэл дамжуулах аргууд, тэдгээрийн хугацаа, цаг агаар, өдөр шөнө, газар орны нөхцөл байдлыг харгалзан холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сонгож ашиглана.

5.8.Онцгой байдлын байгууллагын холбоо, зарлан мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн дараах үүргийг хэрэгжүүлж ажиллана:

5.8.1.гамшгийн голомтод холбоог төлөвлөх;

5.8.2.холбоо зохион байгуулахад хүндрэл үүссэн тохиолдолд хүн хүч, холбоо, мэдээллийн технологийн техник хэрэгслийн дэмжлэг үзүүлэх;

5.8.3.холбоо, мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн байнгын бэлэн байдлыг хангах;

5.8.4.гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод ажиллах холбоочныг томилж, шаардлагатай холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг олгох, хяналт тавих;

5.8.5.төрийн болон албаны нууцад хамаарах мэдээ, мэдээллийг радио холбоогоор дамжуулахгүй байхад хяналт тавих;

5.9.Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод ажиллах холбоочин дараах үүргийг хэрэгжүүлж ажиллана:

5.9.1.холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг шалгаж, хүлээлцэх бүртгэл хөтлөх;

5.9.2.газар орны нөхцөлд тохируулан холбоо барих цэгийг тодорхойлж, холбооны техник хэрэгслийг дэлгэн байгуулах;

5.9.3.гамшгийн голомтод холбоог зохион байгуулах;

5.9.4.гамшгийн голомтод холбоог зохион байгуулахдаа энэхүү журмын "Хүснэгт 9, 10, 11, хавсралт 11, 12, 13-ийг тус тус мөрдөж ажиллана.

5.9.5.гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг тогтоосон цагуудад дээд шатны байгууллагад дамжуулах;

5.9.6.гамшгийн голомтод холбооны болон мэдээлэл технологийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжид саатал гарсан тохиолдолд гэмтлийг тодорхойлж, засварлах;

5.9.7.яаралтай нөхцөл байдалд мэдээллийг дамжуулах холбогдох байгууллага, албан тушаалтныг мэддэг байх;

5.9.8.хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдлөг болгон ажиллах.

Зургаадугаар бүлэг. Албан хэвлэмэл хуудас, холбогдох зардал, техник хэрэгслийг олгох

6.1.Шуурхай бүлгийг гамшгийн голомтод болон хойшлуулшгүй үүрэг гүйцэтгүүлэхэд ашиглах зорилгоор албан хэвлэмэл хуудас, албан томилолтын даалгавар, бэлэн байдлын мөнгө, шатахууны талон, үүрэн холбооны ярианы төлбөрийн картыг зориулалтын хамгаалалттай төмөр шүүгээнд, сансрын холбооны утас, хэт богино долгионы гар радио станц, байршил тодорхойлогч болон бусад хэрэгслийг зориулалтын шүүгээнд хадгална.

6.2.Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн нэгжид энэхүү журмын 6.1-д заасан зүйлсийг 4 дүгээр хавсралтад заагдсан тоо, хэмжээгээр байршуулна. Үүнд:

6.2.1.Улсын Онцгой комиссын асуудал эрхэлсэн нэгж Улсын онцгой комиссын А5, А4 албан хэвлэмэл хуудас (тамгатай, тамгагүй), Улсын онцгой комиссын даргын тушаал А4 албан хэвлэмэл хуудас (тамгатай, тамгагүй), Улсын онцгой комиссын тогтоолын А4 албан хэвлэмэл хуудас (тамгатай, тамгагүй), Улсын онцгой комиссын албан даалгавар, Улсын онцгой комиссын хурлын тэмдэглэлд тусгай дугаарыг олгож, тамгатай байх шаардлага бүхий баримтыг байгууллагын тамгаар баталгаажуулан;

6.2.2.Захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн нэгж Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаал, албан бичгийн А5, А4 хэвлэмэл хуудас (тамгатай, тамгагүй), танилцуулах мэдээний албан хэвлэмэл хуудас, гадаад А4 албан хэвлэмэл хуудас, дугтуй А5, А4 (энгийн, яаралтай) тусгай дугаарыг олгож, тамгатай байх шаардлага бүхий баримтыг байгууллагын тамгаар баталгаажуулан;

6.2.3.Санхүү, ар талын асуудал хариуцсан нэгж бэлэн байдлын мөнгө, шатахууны талон, үүрэн холбооны ярианы төлбөрийн карт, техник хэрэгсэл;

6.2.4.Гамшгийн удирдлагын асуудал хариуцсан нэгж нь "Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед ажиллах шуурхай ажиллагааны удирдамж"-д тусгай дугаарыг олгуулан байгууллагын тамгаар баталгаажуулан;

6.3.Албан хэвлэмэл хуудас, бэлэн байдлын мөнгө, шатахууны талон, үүрэн холбооны ярианы төлбөрийн картыг хүлээн авч хадгалах, техник хэрэгслийг ажилд бэлэн байлгах, томилолтоор үүрэг гүйцэтгэх алба хаагчид хүлээлгэн өгөх, хүлээн авах үйл ажиллагааг холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор хариуцах ба албан хэвлэмэл хуудас, холбогдох зардал, техник, хувцас хэрэгслийг өдөр бүр хүлээлцэж байна.

6.4. Албан хэвлэмэл хуудас, холбогдох зардал, холбооны техник хэрэгслийг хүлээлгэн өгөх, хүлээн авах

6.4.1."Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед ажиллах шуурхай ажиллагааны удирдамж"-ийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрийг үндэслэн Гамшгийн удирдлагын болон Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан нэгжийн даргын зөвшөөрлөөр гамшгийн голомтод болон хойшлуулшгүй ажил үүрэг гүйцэтгэхээр томилогдсон бүрэлдэхүүн хэрэглэнэ.

6.4.2.Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэр, 17 дугаар хавсралтаар батлагдсан удирдамжийг үндэслэн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн нэгжийн даргын зөвшөөрлөөр 3 дугаар хавсралтаар батлагдсан эд, хэрэгслийг холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор 15 дугаар хавсралтаар батлагдсан маягыг бөглүүлэн баримтжуулж, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, ажиллагааг шалган гамшгийн голомтод болон хойшлуулшгүй ажил үүрэг гүйцэтгэхээр томилогдсон алба хаагчид хүлээлгэн өгнө.

6.4.3.Томилолтоор үүрэг гүйцэтгэсэн алба хаагч нь албан томилолтоос ирснээс хойш ажлын 1-2 хоногт багтаан холбогдох зардалд хамаарах баримтыг

бөглөж бүрдүүлэн Санхүү, ар талын асуудал хариуцсан нэгжид, техник хэрэгслийг шуурхай удирдлага, зарлан мэдээллийн нэгжийн операторт, 16 дугаар хавсралтаар батлагдсан маягтыг бөглөн баримтжуулж, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, ажиллагааг шалгуулан хүлээлгэн өгнө.

6.5. Нөхөн бүрдүүлэлт

6.5.1. Гамшгийн голомтод болон хойшлуулшгүй үүрэг гүйцэтгэхээр томилогдсон алба хаагч 4 дүгээр хавсралтаар батлагдсан эд, хэрэгслийг хүлээн авснаас хойш тухайн алба хаагчийн харьяалах бүтцийн нэгж нь Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрийн хувийг ажлын 1-2 хоногт багтаан Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн нэгжид гаргаж өгнө.

6.5.2. Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн нэгж нь 4 дүгээр хавсралтад заагдсан албан хэвлэмэл хуудасны тоо, хэмжээний дөрөвний нэг хувь нь зарцуулагдсан тохиолдолд тухайн хуудаснаас хамааран Улсын онцгой комиссын ажлын алба, Захиргааны удирдлагын болон гамшгийн удирдлагын асуудал хариуцсан нэгжүүдэд хүсэлт гаргах ба тус нэгжүүд нь ажлын 1-2 хоногт багтаан нөхөн бүрдүүлнэ.

6.5.3. Санхүү ар талын асуудал хариуцсан нэгж шуурхай удирдлага, зарлан мэдээллийн нэгжийн хүсэлтийг үндэслэн сансрын холбооны утасны суурь хураамж, ярианы төлбөрийг хийх, бэлэн байдлын мөнгө, шатахууны талон, үүрэн холбооны утасны ярианы төлбөрийн карт, цахилгаан зай хураагуурын нөхөн бүрдүүлэлтийг ажлын 1-2 хоногт багтаан шийдвэрлэнэ.

6.5.4. Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн нэгж нь техник хэрэгсэл эвдэрсэн тохиолдолд засварлуулах, засварлах боломжгүй бол шинээр нөхөн бүрдүүлэлтийг хийхдээ Санхүү ар талын асуудал хариуцсан нэгжид хандан шийдвэрлүүлнэ.

6.5.5. Гамшгийн голомтод болон хойшлуулшгүй үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нь холбоо, мэдээллийн техник хэрэгслийн ашиглалт, бүрэн бүтэн байдлыг хариуцах ба сансрын холбооны утсаар ярьсан тохиолдолд 18 дугаар хавсралтаар батлагдсан маягтыг хөтөлж шуурхай удирдлага, зарлан мэдээллийн нэгжид өгөх үүрэг хүлээнэ.

6.5.6. Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын асуудал хариуцсан нэгж шуурхай удирдлага, зарлан мэдээллийн нэгжид байршуулсан албан хэвлэмэл хуудас, холбогдох зардлын зарцуулалт, техник хэрэгслийн бэлэн байдалд жил бүрийн нэг, гуравдугаар улиралд шалгалт, тооллого хийн хяналт тавина.

6.5.7. Санхүү ар талын асуудал хариуцсан нэгж шуурхай удирдлага, зарлан мэдээллийн нэгжид байршуулсан бэлэн байдлын мөнгө, шатахууны талон, үүрэн холбооны ярианы төлбөрийн картын зарцуулалтын байдалд хагас жил тутамд тооллого хийж хяналт тавина.

6.5.8. Бэлэн байдлын мөнгө, шатахуун талоныг албан бус зүйлд зарцуулсан, техник хэрэгсэл алба хаагчийн буруутай үйлдлээс алдагдсан, эвдрэл, гэмтэл учирсан тохиолдолд зах зээлийн үнэлгээг 2 дахин үнэлж тухайн алба хаагчаар хохирлыг барагдуулна.

Долоодугаар бүлэг. Бусад

7.1. Гамшгийн үеийн шуурхай ажиллагааг зохион байгуулахад Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийг мөрдөж ажиллана.


7.2. Гамшиг, ослын голомтод үүрэг гүйцэтгэж буй бүрэлдэхүүнийг сэлгэн ажиллуулах, амрах, хооллох асуудлыг ажиллагааны удирдагч зохион байгуулна.

7.3. Гамшиг, ослын голомтод үүрэг гүйцэтгэж буй бүрэлдэхүүний томилолтыг хууль, тогтоомжид заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газар олгоно.

7.4.Гамшиг, ослын голомтод үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын эрүүл мэнд, сэтгэлзүйн хангалтыг онцгой байдлын анги байгууллагын эрүүл мэнд-сэтгэлзүйн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтэн хариуцна.

---oOo---

ГАМШГИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ БҮДҮҮВЧ



ШУУРХАЙ АЖИЛЛАГААНД ХӨТЛӨГДӨХ БАРИМТ БИЧИГ

а/ Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн:

1. Ажлын дэвтэр
2. Хоногийн нөхцөл байдлын мэдээ
3. Яаралтай цугларах дохиогоор ажилласан тэмдэглэл, ирцийн бүртгэл
4. Хойшлуулшгүй яаралтай ажлын томилолт олгосон тухай тэмдэглэл
5. Хойшлуулшгүй яаралтай ажлын томилолтын мөнгө олгосон тухай баримт
6. Монгол Улсын гамшгийн нөхцөл байдлын зураг
7. Нийслэл Улаанбаатар хотын бүдүүвч зураг
8. Өдөр тутмын болон долоо хоногийн цаг агаарын мэдээ
9. Бие бүрэлдэхүүний хаяг, байрлалын бүдүүвч

б/ Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн туслах-шуурхай удирдлагын операторын:

1. Радио станцын ажлын дэвтэр
2. Хүлээн авсан мэдээний дэвтэр
3. Явуулсан мэдээний дэвтэр
4. Хүч хэрэгслийн хоногийн мэдээний хуудас
5. Гамшиг, ослын дуудлагын дэлгэрэнгүй бүртгэлийн дэвтэр
6. Иргэдээс ирүүлсэн мэдээллийн бүртгэл

---oOo---

“Шуурхай ажиллагааг зохион байгуулах
журам”-ын 3 дугаар хавсралт

ШУУРХАЙ АЖИЛЛАГААНД АШИГЛАХ ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

а/ Суурин буюу ажлын байранд байх

№	Техник хэрэгслийн нэр		Тоо хэмжээ	Зориулалт
1	Богино долгионы радио станц		1	Аймгийн Онцгой байдлын хэлтсүүдтэй өдөр тутам холбоо хангана.
2	Радио модем		1	Дотоод сүлжээнд холбогдож радиогоор өгөгдөл дамжуулна.
3	Хэт богино долгионы радио станц		1	Хот дотор салбаруудтай холбоо хангана.
4	Телефон аппарат Төрийн холбоо- 263554 “МЦХ” АТС -325726		2	Өдөр тутмын мэдээ, мэдээллийг солилцоно.
5	Факс		1	Шаардлагатай мэдээ, мэдээллийг цаасан хэлбэрээр солилцоно.
6	Компьютер	ажлын компьютер	2	Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн хоногийн нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг боловсруулна.
		хяналтын	1	
7	Хэвлэгч (хар, цагаан)		1	Боловсруулсан мэдээллийг хэвлэнэ.
8	Хэвлэгч, хувилагч (өнгөт)		1	Шаардлагатай мэдээллийг олшруулна. Зарим цаасан мэдээллийг хөрвүүлнэ.
9	Зөөврийн бичил диск (1Gb багтаамжтай)		4	Мэдээ, мэдээллийг зөөвөрлөхөд хэрэглэнэ
10	LCD дэлгэц	кабелийн ТВ	1	Мэдээ, мэдээлэл үзнэ.
		мэдээлэл	1	
		цаг агаарын мэдээлэл	1	
11	Цахилгаан баригч UPS		1	Цахилгааны саатлын үед ашиглана.
12	Цахилгаан үүсгүүр		1	Цахилгааны саатлын үед ашиглана.
13	Проектор		1	Бэлтгэсэн мэдээллийг дэлгэцэд үзүүлнэ.
14	Зөөврийн дэлгэц		1	
15	Интернэт		24 цагаар	тасралтгүй интернэтэд холбогдоно.
16	Мэдээллийн сан		цогц	Шаардлагатай мэдээллийн санг ашиглана.
17	Төмөр шүүгээ		1	Зөөврийн мэдээллийн хэрэгслийг хадгална.

б/ Зөөврийн буюу шуурхай бүлгийн ашиглах

№	Техник хэрэгслийн нэр	Тоо хэмжээ	Зориулалт
1	Хэт богино долгионы гар радио станц (аналоги)	10	Шуурхай бүлгийн бүрэлдэхүүний дотоод холбоо хангана.
2	Хэт богино долгионы гар радио станц (тоон)	10	Шуурхай бүлгийн бүрэлдэхүүний дотоод холбоо хангана.
3	Сансрын холбооны утас Дугаар: 881641462947 881641462938	2	Шуурхай бүлгийн бүрэлдэхүүн хөдөө орон нутагт ажиллах үед телефон холбоо хангана.
4	Байршил тодорхойлогч	1	Шуурхай бүлгийн бүрэлдэхүүн ашиглана.

“Шуурхай ажиллагааг зохион байгуулах
журам”-ын 4 дүгээр хавсралт

ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН НЭГЖИД
БАЙРШУУЛАХ АЛБАН ХЭВЛЭМЭЛ ХУУДАС, ХОЛБОГДОХ ЗАРДАЛ,
ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

№	Зардал, материал хэрэгслийн нэр	Тоо хэмжээ	Нөхөн хангалтыг хариуцах нэгж	
Албан хэвлэмэл хуудас				
1	Улсын онцгой комиссын албан хэвлэмэл хуудас (тамгатай)	20 ширхэг	Улсын онцгой комиссын ажлын алба	
2	Улсын онцгой комиссын албан хэвлэмэл хуудас	20 ширхэг		
3	Албан томилолтын даалгавар	30 ширхэг	Захиргааны удирдлагын газар	
4	Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалын албан хэвлэмэл хуудас А4	20 ширхэг		
5	Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалын албан хэвлэмэл хуудас А4 (тамгатай)	20 ширхэг		
6	Онцгой байдлын ерөнхий газрын А4 албан хэвлэмэл хуудас	20 ширхэг		
7	Онцгой байдлын ерөнхий газрын А4 албан хэвлэмэл хуудас (тамгатай)	20 ширхэг		
8	Онцгой байдлын ерөнхий газрын А5 албан хэвлэмэл хуудас	20 ширхэг		
9	Онцгой байдлын ерөнхий газрын А5 албан хэвлэмэл хуудас (тамгатай)	20 ширхэг		
10	А4 албан хэвлэмэл хуудас (гадаад)	10 ширхэг		
11	А4 дугтуй	10 ширхэг		
12	А5 дугтуй	10 ширхэг		
13	А4 дугтуй (яаралтай)	5 ширхэг		
14	А5 дугтуй (яаралтай)	5 ширхэг		
15	Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед ажиллах шуурхай үйл ажиллагааны удирдамж	10 ширхэг		Ажиллагааны удирдлагын газар
ОБЕГ-ын дэргэдэх, салбар, нэгжийн ШУЗМ-ийн нэгж				
16	НОБГ, ҮАБ, бүсийн төв, орон нутгийн ОБГ, хэлтсийн тус бүр хэвлэмэл хуудас	10 ширхэг	Холбогдох салбар, нэгж	
Бэлэн байдлын мөнгө (зардал)				
1	Албан томилолтын зардал	3.000.000 төгрөг	Санхүү, ар талын газар	
2	Шатахууны талон	2.000.000 төгрөг		
3	Сансрын холбооны утасны ярианы төлбөр	4 утасны төлбөр		
4	Үүрэн холбооны утасны ярианы төлбөрийн карт	Мобиком		60.000 төгрөг
		Скайтел		50.000 төгрөг
		Юнител		50.000 төгрөг
		Жи-мобайл		50.000 төгрөг

Техник хэрэгсэл			
1	Сансрын холбооны гар утас	4 иж бүрдэл	Санхүү, ар талын газар
2	Хэт богино долгионы гар радио станц	15 иж бүрдэл	
3	Богино долгионы үүргэвчийн радио станц	2 иж бүрдэл	
4	Сүлжээ үүсгэгч төхөөрөмжийн дагалдах сим карт	26 ширхэг	
5	Зургийн аппарат	1 ширхэг	
6	Зөөврийн сканер	2 ширхэг	
7	"iPad" төхөөрөмж	4 ширхэг	
8	Зөөврийн компьютер	2 ширхэг	
9	Байршил тодорхойлогч	6 иж бүрдэл	
10	Зөөврийн хатуу диск /hard disk/	2 ширхэг	
11	Зөөврийн бичил диск /hard disk/	4 ширхэг	
12	Бэлэн байдлын тоноглогсон цүнх	2 ширхэг	
13	Цахилгаан зай хураагуур (2А хэмжээ бүхий батарей)	30 ширхэг	
14	Цахилгаан зай хураагуур (3А хэмжээ бүхий батарей)	20 ширхэг	

---oOo---

“Шуурхай ажиллагааг зохион байгуулах
журам”-ын 5 дугаар хавсралт

ХӨДӨЛГӨӨНТ УДИРДЛАГЫН АВТОМАШИНЫ ТОНОГЛОЛ

д/д	Тоног төхөөрөмжийн ангилал	Тоног төхөөрөмжийн төрөл	Нэр	Тоо ширхэг
1	Телефон холбоо	Суурин үүрэн холбооны утас	Ухаалаг утас	2 иж бүрдэл
		Сансрын холбооны утас	Иридиум	1 иж бүрдэл
2	Радио холбоо /Богино болон хэт богино долгионы/	Аналоги системийн радио станц	Машины	1 иж бүрдэл
			Гар радио станц	5 иж бүрдэл
			Үүргэвчийн	1 иж бүрдэл
		Тоон системийн радио станц	Машины радио станц	1 иж бүрдэл
Гар радио бүрдэл	5 иж бүрдэл			
3	Мэдээллийн сүлжээний зөврийн дэд бүтэц	Интернэтийн сүлжээ (суурин болон сансрын)	Интернэтийн сүлжээ үүсгэгч төхөөрөмж	1 иж бүрдэл
			Сүлжээний салаалагч	1ш
			Утасгүй сүлжээний төхөөрөмж	1ш
			Интернэтийн урсгалын хурд	10 мб-аас доошгүй
4	Мэдээллийн систем, тоног төхөөрөмж	Дүрст хурлын төхөөрөмж	Веб камер	1ш
			Спекр, микрофон	1ш
		Теле хяналтын төхөөрөмж	PTZ камер	1ш
			Дүрс нэгтгэгч (NVR)	1ш
5	Мэдээлэл боловсруулах хэрэгсэл	Зөврийн компьютер	Нөүтбүүк	1ш
		Хэвлэх хэрэгсэл	Принтер (3 үйлдэлт)	1 ш
6	Нисгэгчгүй нисэх төхөөрөмж	Нисгэгчгүй нисэх төхөөрөмж	Дрон	1 иж бүрдэл
7	Үл тасалдах цахилгааны эх үүсгүүр	Зөврийн тэжээл үүсгэгч		1 иж бүрдэл
		Нарны зайн үүсгүүр		1 иж бүрдэл
8	Газрын зураг	Газрын зураг	1:100000, 1:200000, 1:500000	3ш
9	Дэлгэц (ухаалаг)			1 иж бүрдэл
10	Бичгийн хэрэгсэл, дагалдах хэрэгсэл			Ажиллах бүрэлдэхүүний тоогоор

ХӨДӨЛГӨӨНТ ХОЛБООНЫ ЗАНГИЛГААНЫ АВТОМАШИНЫ
ТОНОГЛОЛ


д/д	Тонг төхөөрөмжийн ангилал	Тонг төхөөрөмжийн төрөл	Нэр	Тоо ширхэг
1	Телефон холбоо	Үүрэн холбооны утас	Ухаалаг утас	2 иж бүрдэл
		Сансрын холбооны утас	Иридиум	1 иж бүрдэл
2	Радио холбоо (Богино болон хэт богино долгионы)	Аналоги радио станц	Машины	1 иж бүрдэл
			Гар радио станц	5 иж бүрдэл
			Үүргэвчийн	1 иж бүрдэл
			Зөөврийн дахин дамжуулагч	1 иж бүрдэл
		Тоон радио станц	Машины радио станц	1 иж бүрдэл
			Гар радио бүрдэл	5 иж бүрдэл
Зөөврийн дахин дамжуулагч	1 иж бүрдэл			
3	Мэдээллийн сүлжээний тоног төхөөрөмж	Интернэтийн сүлжээ	Интернэтийн сүлжээ үүсгэгч төхөөрөмж	1 иж бүрдэл
			Сүлжээний салаалагч	1ш
			Утасгүй сүлжээний төхөөрөмж	1ш
4	Дүрст хурлын систем	Дүрст хурлын төхөөрөмж	Веб камер	1ш
			Спекр, микрофон	1ш
5	Мэдээлэл боловсруулах хэрэгсэл	Зөөврийн компьютер	Нөүтбүүк	1ш
		Хэвлэх хэрэгсэл	Принтер (3 үйлдэлт)	1 ш
6	Нисгэгчгүй нисэх төхөөрөмж	Нисгэгчгүй нисэх төхөөрөмж	Дрон	1 иж бүрдэл
7	Үл тасалдах цахилгааны эх үүсгүүр	Зөөврийн тэжээл үүсгэгч		1 иж бүрдэл
		Нарны зайн үүсгүүр		1 иж бүрдэл
8	Дэлгэц (ухаалаг)			1 иж бүрдэл
9	Дамартай уртасгагч			100м

"Шуурхай ажиллагааг зохион байгуулах
журам"-ын 7 дугаар хавсралт

ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ХӨДӨЛГӨӨНТ
УДИРДЛАГЫН ТӨВ (АВТОМАШИН)-ИЙН ТОНОГЛОЛ

д/д	Тоног төхөөрөмж	Тоо хэмжээ
1	Телевизийн өргөн нэвтрүүлэг хүлээн авагч	1ш
2	Радио өргөн нэвтрүүлэг хүлээн авагч /FM/	1ш
3	Холигч	1ш
4	Хэт богино долгионы станц	5ш
5	Хэт богино долгионы станц.	1ш
6	Чанга яригч	1ш
7	Тог баригч	1ш
8	Хэт богино долгионы дахин дамжуулах станц	6ш
9	Сансарын холбооны хүлээн авагч /SR2000R/	1ш
10	Цахилгаан үүсгүүр	1ш
11	Агааржуулагч	1ш
12	Сансрын холбооны автомат антен	1 ком
13	GPS антен	1ш
14	Штер антен	5ш


ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН "ЯАРАЛТАЙ ЦУГЛАР", "ЦУГЛАР" ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ДОХИОГ ДАМЖУУЛАХ БҮДҮҮВЧ



Дохионы код	
1.	Улаан
2.	Улбар шар
3.	Шар
Дохио дамжуулах хэрэгсэл	
1.	Үүрэн холбоо
2.	Телефон холбоо
3.	Радио холбоо
4.	Хөдөлгөөнт хэрэгсэл
Дохио дамжуулагч	
→	ШУЗМТ
→	Газар, хэлтсийн дарга нар


"Шуурхай ажиллагааг зохион байгуулах журам"-ын 9 дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХҮРЭЭНД "ЯАРЛТАЙ ЦУГЛАР", "ЦУГЛАР" ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ДОХИОГ ДАМЖУУЛАХ БҮДҮҮВЧ



Дохионы код	
1	Улаан
2	Улбар шар
3	Шар
Дохио дамжуулах хэрэгсэл	
1	Үүрэн холбоо
2	Телефон холбоо
3	Радио холбоо
4	Хөдөлгөөнт хэрэгсэл
Дохио дамжуулагч	
→	ШУЭМТ
-----	НОБГ-ын дэд төв
→	Газар, хэлтсийн дарга нэр


ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ХЭМЖЭЭНД "ЯАРАЛТАЙ ЦУГЛАР", "ЦУГЛАР" ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ДОХИОГ ДАМЖУУЛАХ БҮДҮҮВЧ



Дохियोны код	
1	Улаан
2	Уулбар шар
3	Шар
Дохийо дамжуулах хэрэгсэл	
1	Турал холбоо
2	Телефон холбоо
3	Радио холбоо
4	Хөдөлгөөнт хэрэгсэл
Дохийо дамжуулагч	
ШУЗМТ	
---	НОБГ-ын дэд төв
---	Газар, хэлтсийн дарга нар
---	Бүсийн төвийн ОБГ-ын ШУЗМТ

ГАМШГИЙН ҮЕИЙН РАДИО ХОЛБОО ЗОХИОН БАЙГУУЛАХ БҮДҮҮВЧ

Тоон системийн радио станц:




(DD-01) - Үндсэн суваг буюу нэгдсэн сүлжээнд холбогдсон суваг

(NS-01) - Салбар, бүлгийн харилцан ажиллагааны нэгдсэн сүлжээний нөөц
холбооны суваг


“Шуурхай ажиллагааг зохион байгуулах журам”-ын 12 дугаар хавсралт

ГАМШГИЙН ГОЛОМТОД ХОЛБОО ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗУРАГЛАЛ



“Шуурхай ажиллагааг зохион байгуулах
журам”-ын 13 дугаар хавсралт

ТООН СИСТЕМИЙН ДАХИН ДАМЖУУЛАГЧИЙН РАДИО СТАНЦЫН
НЭГДСЭН СҮЛЖЭЭНИЙ ТОР



	Газар, хэлтэс	Салбар нэгж (ГТУАА)	Үндсэн суваг	Нөөц суваг	БГД	БЗД	СХД	СБД	ЧД	ХУД
1	Онгой байдлын ерөнхий газар	-	DD-01	NS-01						
2	Үндэсний аврах бригад	-								
3	БГД-ийн ОБХ	18								
4		11								
5	СХД-ийн ОБХ	26								
6		29								
7	ШУЗМТ 119 дүгээр анги	-	DD-02	NS-02	DD-01 NS-01	DD-04 NS-04	DD-01 NS-01	DD-01; DD-02 NS-01; NS-02	DD-02 NS-02	DD-03; DD-01 NS-03; NS-01
8	МШУТ	-								
9	НОБГ-ын дэд төв	-								
10	ЧД-ийн ОБХ	10								
11	СБД-ийн ОБХ	34								
12		74								
13	АЭХА 111 дүгээр анги	-	DD-03	NS-03						
14		14								
15	ХУД-ийн ОБХ	30								
16		65								
17		35	DD-04	NS-04						
18	БЗД-ийн ОБХ	63								

"Шуурхай ажиллагааг зохион байгуулах
журам"-ын 14 дүгээр хавсралт

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСТАЙ МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ТАЛААР:

Удирдлагын түвшинд

д/д	Улс	Байгууллага	Утас	Цахим шуудан
1.	БНХАУ	Онцгой байдлын удирдлагын яам	+86-10-83933714 +86-10-83933407	wgy_wiggy@126.com

Бүс нутгийн түвшинд

д/д	Улс	Байгууллага	Утас	Цахим шуудан
Дорнод аймгийн Онцгой байдлын газар				
1.	БНХАУ- ӨМӨЗО	Хянган аймаг /Улаанхот/	-	-
2.		Хөлөнбуйр хот /Хайлаар дүүрэг/	+8613754000085	Wechat 13754000085
3.		Шинэ Барга зүүн хошуу	+8613191312567	Wechat 13191312567
4.		Шинэ Барга баруун хошуу	+8613191312567	Wechat 13191312567
Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газар				
1.	БНХАУ- ӨМӨЗО	Шилийн гол аймаг /Шилийн хот/	-	wechat ID: dwajsj Region: inner Mongolia Xilingol
2.		Авга хошуу	-	-
3.		Зүүн үзэмчин хошуу	-	-

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСТАЙ МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ТАЛААР:

Удирдлагын түвшинд

д/д	Улс	Байгууллага	Утас	Цахим шуудан
1.	ОХУ	Онцгой байдлын яамны Хямралын удирдлага, зарлан мэдээлэх үндэсний төв	+7(499) 989-55-26 +7(495) 983-64-68	ods@mchs.gov.ru

Бүс нутгийн түвшинд

д/д	Улс	Байгууллага	Утас	Цахим шуудан
Булган, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газар				
1.	ОХУ	Онцгой байдлын яамны БНБУ дахь ерөнхий газар	+7-301-221-40-42 +7-301-221-96-01	01cuks@03.mchs.gov.ru
Баян-Өлгий, Завхан, Увс аймгийн Онцгой байдлын газар				
1.	ОХУ	Онцгой байдлын яамны БНТУ дахь ерөнхий газар	+7-394-222-64-42	cuks@17.mchs.gov.ru
Дорнод, Хэнтий аймгийн Онцгой байдлын газар				
1.	ОХУ	Онцгой байдлын яамны Өвөр байгалийн хязгаар дахь ерөнхий газар	+7-302-223-08-43 +7-302-223-08-49	cuks75@mail.ru

"Шуурхай ажиллагааг зохион байгуулах
журам"-ын 15 дугаар хавсралт

АЛБАН ХЭВЛЭМЭЛ ХУУДАС, ХОЛБОГДОХ ЗАРДАЛ, ХОЛБООНЫ ТЕХНИК
ХЭРЭГСЭЛ ОЛГОХЫГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Дугаар

Огноо: Газар, хэлтэс:

Албан тушаал: Цол, Овог, Нэр:

Хэний шийдвэрээр:

Бэлэн мөнгө/дүн: Шатахууны талон/дүн: ҮХ-ны ярианы карт/дүн:

Хэвлэмэл хуудас: Нэр, тоо

Техник, хэрэгсэл: Нэр, тоо

Томилгоот ажил/Хойшлуулшгүй ажил (доогуур нь зурах)

Ажлын товч агуулга/Зориулалт

Техник хэрэгслийн бүрдэл, ажиллагааг шалгаж хүлээн авсан болно.

Баталгаажилт:

(гарын үсэг)

Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан операторын бөглөх хэсэг

Үлдэгдэл:
Бэлэн мөнгө/дүн: Шатахууны талон/дүн: ҮХ-ны ярианы карт/дүн:

Хэвлэмэл хуудас: Нэр, тоо

Техник, хэрэгсэл: Нэр, тоо

Баталгаажилт:

(цол, овог, нэр)
(гарын үсэг)

“Шуурхай ажиллагааг зохион байгуулах
журам”-ын 16 дугаар хавсралт

ХОЛБООНЫ ТЕХНИК ХЭРЭГСЭЛ ХҮЛЭЭЛЦСЭН БАРИМТ

Дугаар

Хүлээлгэн өгсөн:

Огноо:

Газар, хэлтэс:

--	--

Албан тушаал:

Цол, Овог, Нэр:

--	--

Баталгаажилт:

.....

(Гарын үсэг)

Хүлээн авсан:

Өргөдлийн дугаар:

--

Техник, хэрэгсэл: Нэр, тоо

--

Техник хэрэгслийн бүрдэл, ажиллагааг шалгаж хүлээн авсан болно.

Баталгаажилт: Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор

..... /
(гарын үсэг)

..... /
(цол, овог, нэр)
(гарын үсгийн тайлал)

ГАМШИГ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСЛЫН ҮЕД АЖИЛЛАХ
ШУУРХАЙ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

20 ... оны ... сарын ...-ны өдөр

№.....

1. Гамшиг, аюулт үзэгдэл, осол гарсан газар нутгийн нэр,
солбилцол.....

2. Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэр.....

3. Томилогдсон алба хаагч:

- | | | | |
|----|----------------|-------|-------------|
| a. | | (цол) | (Овог, нэр) |
| | (албан тушаал) | | |
| b. | | (цол) | (Овог, нэр) |
| | (албан тушаал) | | |
| c. | | (цол) | (Овог, нэр) |
| | (албан тушаал) | | |
| d. | | (цол) | (Овог, нэр) |
| | (албан тушаал) | | |

4. Нисдэг тэрэг. Байгууллага загвар

a. Автомашинy улсын дугаар загвар

Тайлбар.....Томилогдсон

..... он сар өдөр

Голомтод очсон он сар өдөр цаг минут

Голомтоос буцсан он сар өдөр цаг минут

ОБЕГ-т ирсэн он сар өдөр цаг минут

5. Үйл ажиллагааны тэмдэглэл

Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Түймэрт өртсөн /га/ талбай /урьдчилсан байдлаар/

ДАРГА

“Шуурхай ажиллагааг зохион байгуулах
журам”-ын 18 дугаар хавсралт

САНСРЫН ХОЛБООНЫ УТАСНЫ ЯРИАНЫ ТЭМДЭГЛЭЛ

	Огноо	Албан тушаал	Овог, нэр	Цол	Утасны дугаар	Ярьсан хугацаа	Гарын үсэг	Гарын үсгийн тайлал

---oOo---

**БАЯР АМРАЛТЫН ӨДРҮҮДЭД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ШУУРХАЙ БҮЛГИЙН
БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОМИЛГОО**

1. Цаг агаарын гамшигт үзэгдэл болсон үед ажиллах шуурхай бүлэг	
Шуурхай бүлгийн ахлагч:	Ажиллагааны удирдлагын газрын Дэд бүтэц, газар хөдлөлтийн тасгийн дарга
Гишүүд:	Урьдчилан сэргийлэх газрын цаг уур, экологийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Мэдээлэл технологийн хэлтсийн радио холбоо, зарлан мэдээллийн систем хариуцсан мэргэжилтэн
	Бусад шаардлагатай албан тушаалтан
2. Томоохон хэмжээний объектын болон ой, хээрийн гал түймэр гарсан үед ажиллах шуурхай бүлэг	
Шуурхай бүлгийн ахлагч:	Гал түймэр унтраах, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга
Гишүүд:	Гал түймэртэй тэмцэх газрын хяналтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
	Гал түймэртэй тэмцэх газрын хөдөлмөр хамгаалал, ой хээрийн гал түймрийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
	Бусад шаардлагатай албан тушаалтан
3. Олныг хамарсан хоолны хордлогын үед ажиллах шуурхай бүлэг	
Шуурхай бүлгийн ахлагч:	Ажиллагааны удирдлагын газрын гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Санхүү, ар талын газрын Эрүүл мэндийн тасгийн хөдөлмөрийн эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн
	Ажиллагааны удирдлагын газрын цацраг хими, биологийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Ажиллагааны удирдлагын газрын хүний гоц халдварт өвчлөл хариуцсан мэргэжилтэн
	Бусад шаардлагатай албан тушаалтан
4. Мал амьтны халдварт болон гоц халдварт өвчин гарсан үед ажиллах шуурхай бүлэг	
Шуурхай бүлгийн ахлагч:	Ажиллагааны удирдлагын газрын Дэд бүтэц, газар хөдлөлтийн тасгийн дарга
Гишүүд:	Ажиллагааны удирдлагын газрын мал, амьтны гоц халдварт өвчлөл хариуцсан мэргэжилтэн
	Ажиллагааны удирдлагын газрын хүний гоц халдварт өвчлөл хариуцсан мэргэжилтэн
	Бусад шаардлагатай албан тушаалтан
5. Уул уурхай, үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж барилга байгууламж, шугам сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт болон аюултай бодис алдагдсан үед ажиллах шуурхай бүлэг	
Шуурхай бүлгийн ахлагч:	Ажиллагааны удирдлагын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, улсын хяналтын хэлтсийн дарга
Гишүүд:	Ажиллагааны удирдлагын газрын гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн

	Ажиллагааны удирдлагын газрын уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Ажиллагааны удирдлагын газрын цацраг хими, биологийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Бусад шаардлагатай албан тушаалтан
6. Террорист халдлага, дэлбэрэлт болсон үед ажиллах шуурхай бүлэг	
Шуурхай бүлгийн ахлагч:	Ажиллагааны удирдлагын газрын дарга
Гишүүд:	Ажиллагааны удирдлагын газрын тэсэрч дэлбэрэх бодисын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Ажиллагааны удирдлагын газрын хүний гоц халдварт өвчлөл хариуцсан мэргэжилтэн
	Бусад шаардлагатай албан тушаалтан

---oOo---

ШУУРХАЙ ШТАБЫН ҮНДСЭН БОЛОН НӨӨЦ БҮРЭЛДЭХҮҮН

№	Шуурхай штаб-10 хүн	
	Үндсэн бүрэлдэхүүн	Нөөц бүрэлдэхүүн
1	Онцгой байдлын ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга	Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга
2	Ажиллагааны удирдлагын газрын дарга	Мэргэжлийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга
3	Гал түймэртэй тэмцэх газрын дарга	Гал түймэр унтраах, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга
4	Урьдчилан сэргийлэх газрын дарга	Гамшгаас хамгаалах, сургалт сурталчилгааны хэлтсийн дарга
5	Захиргааны удирдлагын газрын дарга	Захиргааны удирдлагын хэлтсийн дарга
6	Санхүү, ар талын газрын дарга	Ар тал, хангалтын хэлтсийн дарга
7	Бодлого, төлөвлөлтийн газрын дарга	Стратегийн төлөвлөлтийн хэлтсийн дарга
8	Эрсдэлийн удирдлагын газрын дарга	Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээний хэлтсийн дарга
9	Улсын нөөцийн газрын дарга	Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн хэлтсийн дарга
10	Олон нийттэй харилцах төвийн дарга	Сурталчилгаа, олон нийттэй харилцах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

---oOo---

ШУУРХАЙ БҮЛГИЙН ҮНДСЭН БОЛОН НӨӨЦ БҮРЭЛДЭХҮҮН

№	Шуурхай бүлэг-10 хүн	
	Үндсэн бүрэлдэхүүн	Нөөц бүрэлдэхүүн
1	Ажиллагааны удирдлагын газрын дарга	Гал түймэртэй тэмцэх газрын дарга
2	Ажиллагааны удирдлагын газрын Мэргэжлийн удирдлага зохицуулалтын хэлтсийн дарга	Гамшгаас хамгаалах төлөвлөлт, улсын хяналтын хэлтсийн дарга
3	Ажиллагааны удирдлагын газрын гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн	Ажиллагааны удирдлагын газрын гамшгаас хамгаалах дайчилгаа, нүүлгэн шилжүүлэлт, улсын албад хариуцсан ахлах мэргэжилтэн
4	Гал түймэр унтраах, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга	Гал түймэр унтраах, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хэлтсийн гал унтраах бэлтгэл, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн
5	Гал түймэр унтраах, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хэлтсийн Ой хээрийн түймэртэй тэмцэх асуудал хариуцсан мэргэжилтэн	Гал түймэр унтраах, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хэлтсийн техник, зэвсэглэмж, хорт хий утаанаас хамгаалах болон хөдөлмөр хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн
6	Ажиллагааны удирдлагын газрын дэд бүтэц, газар хөдлөлтийн тасгийн дарга	Дэд бүтэц, газар хөдлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн
7	Ажиллагааны удирдлагын газрын аврах ажлын технологи хариуцсан ахлах мэргэжилтэн	Ажиллагааны удирдлагын газрын Уул уурхай аврах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
8	Ажиллагааны удирдлагын газрын цацраг, хими, бактерлогийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн химич судлаач
9	Ажиллагааны удирдлагын газрын тэсэрч, дэлбэрэх бодисын асуудал хариуцсан мэргэжилтэн	
10	Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газрын Улсын нөөц хүмүүнлэгийн тусламжийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газрын хүнсний барааны нөөц, хүмүүнлэгийн тусламж хариуцсан мэргэжилтэн

---oOo---

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АНГИ, САЛБАР,
 БҮТЦИЙН НЭГЖҮҮД ГАМШИГ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСЛЫН ҮЕД
 ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХЭД БЭЛЭН БОЛОХ ХУГАЦАА

д/д	Нэгжийн нэр		Бэлэн болгох хугацаа (минутаар)			
			Дулааны улиралд		Хүйтний улиралд	
			Өдөр	Шөнө	Өдөр	Шөнө
1	Онцгой байдлын ерөнхий газар болон дэргэдэх анги	шуурхай штаб	Ц+30 мин	Ц+00.50 мин	Ц+30 мин	Ц+70 мин
		бие бүрэлдэхүүн	Ц+70 мин	Ц+00.50 мин	Ц+90 мин	Ц+70 мин
2	Үндэсний аврах бригад	шуурхай штаб	Ц+30 мин	Ц+00.50 цаг	Ц+30 мин	Ц+70 мин
		бие бүрэлдэхүүн	Ц+70 мин	Ц+00.50 мин	Ц+90 мин	Ц+70 мин
3	Орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбар	шуурхай штаб	Ц+30 мин	Ц+40 мин	Ц+30 мин	Ц+60 мин
		бие бүрэлдэхүүн	Ц+40 цаг	Ц+60 мин	Ц+ 50 цаг	Ц+60 мин
4	Нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбар	шуурхай штаб	Ц+30 мин	Ц+50 мин	Ц+30 мин	Ц+70 мин
		бие бүрэлдэхүүн	Ц+90 цаг	Ц+60 мин	Ц+ 90 цаг	Ц+90 мин

---oOo---

МАТЕРИАЛ ХЭРЭГСЛИЙН НӨӨЦ

д/д	Нөөцийн нэр	Нөөцийн ангилал	Хэмжих нэгж
1	Хүнс	Байнгын нөөц	10 хоног
		Хангалтын нөөц	30 хоног
2	Дулаан хувцас	Байнгын нөөц	б/б 60 хувь
		Хангалтын нөөц	б/б 80 хувь
3	Шатахуун	Байнгын нөөц	1 цэнэг
		Хангалтын нөөц	2 цэнэг
4	Түлш	Байнгын нөөц	20 хоног
5	Холбоо	Хэт богино долгионы радио станц	3 ш
		Богино долгионы радиостанц	3 ш
		Хэт богино долгионы гар станц	10 ш

---oOo---

ШУУРХАЙ ШТАБЫН БАЙРНЫ ИЖ БҮРДЭЛ

д/д	Эд зүйлийн нэр	тоо/хэмжээ
Удирдлагын баримт бичиг		
1	Холбогдох хууль, эрх зүйн дүрэм, журам, заавар, тушаал, шийдвэр	
2	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө болон бусад чиглэлийн төлөвлөгөөнүүд	
3	Тушаал, шийдвэрийн төслүүд (гамшгийн төрөл тус бүрээр цагийн байдлын хувилбар)	6-аас доошгүй
4	Тактикийн таних тэмдэг	1ш
5	Байр зүйн зураг (Масштаб 1:50000, :200000)	1ш
6	Тухайн газар орон барилга байгууламжийн план зураг	1ш
Бичгийн хэрэгсэл		
1	Бичгийн цаас	2 боодол
2	Жижиг хайч	1 ш
3	Цаасны цавуу	1 ш
4	Кноп	1 хайрцаг
5	Цаасны хутга	1ш
6	Цаас үдэгч, хавчигч,	1ш
7	Арилгагч	1ш
8	Өнгийн харандаа	1 иж
9	Бичгийн дугтуй том, жижиг тус бүр	10 ш
10	Өсгөгч шил	1ш
11	Байр зүйн зураг өлгөгч	1ш
Техник хэрэгсэл		
1	Зөөврийн компьютер	1ш
2	Хэвлэгч, хувилагч төхөөрөмж (тус бүр)	1ш
3	Дүрс бичлэгийн камер	1ш
4	Зургийн аппарат	1ш
Холбооны хэрэгсэл		
1	Богино долгионы радио станц	2ш
2	Хэт богино долгионы гар станц	8ш
3	Телефон утас	2ш
4	Байршил тогтоогч	1ш
5	Зөөврийн GPS	1ш

---oOo---

ШУУРХАЙ БҮЛЭГТ БАЙХ ИЖ БҮРДЭЛ

д/д	Эд зүйлийн нэр	тоо/хэмжээ
1	Албан томилолт	алба хаагч бүр
2	Гүйцэтгэх үүргээс хамаарч аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдээс бүрдэнэ.	
3	Дүрс бичлэгийн камер (нөөц тэжээлийн хамт)	1ш
4	Зургийн аппарат	1ш
5	Дохионы буу (сумны хамт)	1ш
6	Газар орны байр зүйн болон план зураг	1ш
Холбооны хэрэгсэл		
1	Богино долгионы радио станц (үүргэвчин)	1ш
2	Сансрын холбооны (иридиум) гар утас	1ш
3	Хэт богино долгионы автомашины /станц	1ш
4	Байрлал тодорхойлох багаж (GPS)	1ш
5	Зөөврийн гар чийдэн	1ш
Бусад хэрэгсэл		
1	Хүнс	3 хоног
2	Эмнэлгийн аяны үүргэвч (шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал)	
3	Зөөврийн цахилгаан үүсгүүр	1ш
4	Хээрийн гал тогооны иж бүрдэл (5 хүн)	1ш
5	Хийн түлш	(нөөц хий 8 ш)
6	Аяны майхан (2-3 хүн)	1ш

---oOo---

ХЭЭРИЙН БОЛОН ХӨДӨЛГӨӨНТ УДИРДЛАГЫН БАЙР

а/ Хээрийн удирдлагын суурин байр

д/д	Бүлгийн байр		Хүний тоо	Шаардагдах байр, тоо хэмжээ		Тайлбар
				Өвөл	Зун	
1	Суурин удирдлагын байр		9	Асар – 1, 8*6	Асар – 1, 10*8	Бүлгийн бүрэлдэхүүнийг ажиллах, амрахад шаардлага тай тавилга, хэрэгслээр хангана.
2	Суурин штабын байр	Шуурхай бүлэг	15-20	Асар – 1, 9*12	Асар – 1, 12*14	
		Төлөвлөлтийн бүлэг				
		Ажиллагааны бүлэг				
		Холбооны бүлэг				
		Мэдээлэл сурталчилгааны бүлэг				
Хангалтын бүлэг						
3	Шуурхай ажиллагааны бүлгийн байр		6	Майхан 1, 4*4		

б/ Хөдөлгөөнт удирдлагын байр

д/д	Бүлгийн байр		Хүний тоо	Шаардагдах байр, тоо хэмжээ		Тайлбар
				Өвөл	Зун	
1	Хөдөлгөөнт удирдлагын байр		14	Туулах чадвар сайтай том оврын чиргүүлтэй автомашин 1 ш		Бүлгийн бүрэлдэхүүнийг ажиллах, амрах зориулалтай
2	Хөдөлгөөнт штабын байр	Шуурхай бүлэг	4-10	Туулах чадвар сайтай автомашин 1 ш		
		Төлөвлөлтийн бүлэг				
		Үйл ажиллагааны бүлэг				
		Холбооны бүлэг				
		Мэдээлэл сурталчилгааны бүлэг				
Хангалтын бүлэг						
3	Шуурхай ажиллагааны бүлгийн байр		10 хүн	Майхан 2, 4*4		

---oOo---

БОГИНО ДОЛГИОНЫ РАДИО ХОЛБОО ТОГТООХ ДАРААЛАЛ

Радио станцын дуудлага	Нэвтрүүлэх	Хүлээн авах	Баталгаажуулах
Ерөө-1	"Ерөө" "Ерөө-1"-ийг сонсож байна уу хариу		
Ерөө		Би "Ерөө" "Ерөө-1"-ийг сонсож байна.	
Ерөө-1	"Ерөө" радио мэдээ хүлээн авна уу.		
Ерөө		Би Ерөө хүлээн авахад бэлэн	
Ерөө-1	Би "Ерөө-1" шуурхай бүлэг ажиллаж дууслаа.		
Ерөө			Би "Ерөө" шуурхай бүлэг ажиллаж дууслаа гэж хүлээн авлаа зөв үү?
Ерөө-1			Би "Ерөө-1" зөв
Ерөө-1	Дараагийн холбоонд орох цаг 11 цаг 30 минут		
Ерөө		Би Ерөө байнгын хүлээн авалтад байна.	

---oOo---

БОГИНО ДОЛГИОНЫ РАДИО ХОЛБООНД ОРОХ ДАРААЛАЛ, ДУУДЛАГА

Аймаг, нийслэлийн нэр	НОВГ

РАДИО СТАНЦЫН СУВГИЙН ДАРААЛАЛ

№	Хамрах хүрээ	Горим	Суваг	Сувгийн нэр	Үелзэл /RX Мгц/	Үелзэл /TX Мгц/	Горим
АНАЛОГИ СИСТЕМИЙН ХЭТ БОГИНО ДОЛГИОНЫ РАДИО ДАВТАМЖ							
1	Төв, орон нутгийн анги байгууллагын хэмжээнд	Станцын горим	1	OBA-1	-	-	Шууд харалтын 1-5 км/Симплекс
2			2	OBA-2	-	-	
3			3	OBA-3	-	-	
4			4	OBA-4	-	-	
5	Нийслэлийн Онцгой байдлын газар	Дахин дамжуулах станцын горимд ажиллах үелзэл	5	NOBG-1	-	-	Нөөц нэгдсэн суваг/Дуплекс
6			6	NOBG-2	-	-	
7			7	NOBG-3	-	-	
8	Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хэмжээнд төв газруудад	Дахин дамжуулах станцын горимд ажиллах хэмжээнд төв газруудад	8	DD-101	-	-	Нөөц нэгдсэн суваг/Дуплекс
9			9	DD-102	-	-	
10			10	DD-103	-	-	
11			11	DD-104	-	-	
12			12	DD-105	-	-	
13			13	DD-106	-	-	
14			14	DD-107	-	-	
ТООН СИСТЕМИЙН ХЭТ БОГИНО ДОЛГИОНЫ РАДИО ДАВТАМЖ							
1	Нийслэлийн хүрээний Онцгой байдлын анги байгуулга		1	DD-01	-	-	Нэгдсэн суваг/Дуплекс
2			2	DD-02	-	-	
3			3	DD-03	-	-	
4			4	DD-04	-	-	
5			5	NS-01	-	-	Нөөц нэгдсэн суваг/Дуплекс
6			6	NS-02	-	-	
7			7	NS-03	-	-	
8			8	NS-04	-	-	

---oOo---